

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БАТЛАВ: БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУИ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ГОВЬШОО ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С. ГАНБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
ГОВЬШОО ХХК-ИЙН ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5060338/


Хянасан:

ХУОБХГазрын Байгаль Орчны, Үнэлгээ Аудитын хэлтсийн мэргэжилтэн

С.Нямжав

Боловсруулсан:

"Дорнын байгаль" ХХК-ийн гүйцэтгэх захирал



Б.Батчимэг

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

АГУУЛГА

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....	5
1.1. Төслийн талаарх мэдээлэл.....	5
1.3. Ашиглалтын системийн сонголт	12
Далд уурхайн ажиллах горим	12
Уурхайн календарь төлөвлөгөө	13
Баяжуулалт.....	15
1.4. 2024 уулын ажлын төлөвлөгөө.....	24
Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	29
2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал	29
2.3. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал.....	29
2.4. Төслийн талбайн гадаргын болон газрын доорх усны төлөв байдал	31
2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал:	35
2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал	37
2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг.....	40
2.8.Нийгэм, эдийн засаг өнөөгийн төлөв байдал:.....	40
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	41
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ...	41
3.2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл	41
3.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	42
3.4. Ургамлан бүрхэвчид, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	42
3.5. Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл:.....	43
Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	44
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	45
Бүлэг 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	47
Бүлэг 7. Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах, ТЭрбум мод хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө	47
Бүлэг 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	47
Бүлэг 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	47
Бүлэг 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	48
Бүлэг 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	49
БҮЛЭГ 12. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..	50
Бүлэг 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	51
Бүлэг 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	56
Бүлэг 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	56
Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт	56
Хавсралт	59
.....	59

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн байршил	5
Хүснэгт 2. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	9
Хүснэгт 3. Эдийн засгийн үзүүлэлтүүд	10
Хүснэгт 4. Ордын анх батлагдсан геологийн нөөц.....	12
Хүснэгт 5. Далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ	13
Хүснэгт 6. Малталт нэвтрэлтийн ӨТА-н тооцоо	13
Хүснэгт 7. Малталт нэвтрэлтийн ажилд хэрэглэх ТБ-ын зарцуулалт	14
Хүснэгт 8. Хүдэр нураалтын ӨТА-н тооцоо	14
Хүснэгт 9. 2024 онд нийт зарцуулах ТМ-ын жагсаалт	15
Хүснэгт 10. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	19
Хүснэгт 11. Технологийн схем.....	19
Хүснэгт 12. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт	20
Хүснэгт 13. Урвалж бодисын зайлшгүй байх нөөц.....	23
Хүснэгт 14. Флотацийн процесст хэрэглэгдэх урвалжийн зарцуулалт	23
Хүснэгт 15. Далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ	24
Хүснэгт 16. Тээвэрлэх ачааны хэмжээ	28
Хүснэгт 17. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	46
Хүснэгт 18. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	48
Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	49
Хүснэгт 20. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал.....	50
Хүснэгт 21. 2024 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	52
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний дээж авах цэгийн координат	55
Хүснэгт 23. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт.....	58

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зургийн жагсаалт

Зураг- 1. Төслийн талбайн байршил.....	6
Зураг- 2. Төслийн талбайн хүрээлэн буй орчны төлөв байдлыг сансрын зургаар харуулав (М 1:30000)	7
Зураг- 3. <i>Баяжуулах үйлдвэрийн талбайн байршил</i>	16
Зураг- 4. Лог - Баянжаргалан чиглэлийн сайжруулсан шороон зам	26
Зураг- 5. Хөөт – Олон-Овоот өртөө чиглэлийн сайжруулсан шороон зам.....	27
Зураг- 6. Гадаад тээврийн замын зураг	28
Зураг- 7. Далд уурхайн төлөвлөсөн гол амуудын байршил	31

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн талаарх мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Говь шоо” ХХК Регистрийн дугаар: 5060338; Улсын бүртгэлийн дугаар: 9011020042; Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Чингүүнжавын гудамж, АОС-33; - Утас: 95956153, 99037739

Төслийн нэр: “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”



Төслийн байршил: “Говь шоо” ХХК-ийн Логийн хайлуур жоншны орд нь засаг захиргааны харьяаллын хувьд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км-т, Дундговь аймгийн Баянжаргалан сумаас өмнө зүгт 28 км-т, Чойрын төмөр замын өртөөнөөс баруун урагш 110 км-т, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн зүгт 150 км-т тус тус байрлана (Зураг 1).

Хүснэгт 1. Төслийн талбайн байршил


Тусгай зөвшөөрөл	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-017543 (48.24 гектар)	2011-05-25	30	1	107° 52' 21.52"	45° 34' 11.61"
			2	107° 51' 57.51"	45° 34' 11.61"
			3	107° 51' 57.51"	45° 34' 41.61"
			4	107° 52' 21.52"	45° 34' 41.61"

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн хүрээлэн буй орчны төлөв байдлыг сансрын зургаар харуулав (М 1:30000)



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

“Говь шоо” ХХК нь “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл (MV-017543)”-ийн талбайд 2015-2018 онд хайгуулын ажил гүйцэтгэн, ордын хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой зэргээр $B+C=224.68$ мян.тн-оор Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Логийн хайлуур жоншны ордыг анх 1955 онд нээсэн байна. Д.Цогтбаяр, С.Мягмар нар 1988-1990 онуудад Хөх дэлийн хүдрийн талбайд эрэл-үнэлгээний ажил явуулсан бөгөөд уг талбайн нь Сүүл-Өндрийн хүдрийн зангилааны өмнөд жигүүрт багтжээ. Ус эрлийн ажлын явцад Сүүл-Өндрийн зангилааны хэмжээнд хайлуур жоншны 30 орчим хүдрийн биет ялган 7 бүс тогтоож, эдгээрийн жоншны нийт нөөцийг 2313 мян.тн-оор тогтоосон байдаг.

ЭБЭХЯ-ны харьяа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2009 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 10-06 дугаар дүгнэлтийг үндэслэн АМГ-ын даргын 2009 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 221 тоот тушаалаар Логийн хайлуур жоншны ордын I биетийн өмнөд хэсгийн нөөцийг бодитой болон боломжтой ($B+C$) зэргээр 67.827 мян.тн хүдэрт 56.02%-ийн дундаж агуулгатай 37.996 мян.тн эрдэс, үүнээс бодитой (B) зэргээр 44.830 мян.тн хүдэрт 56.82%-ийн дундаж агуулгатай 25.024 мян.тн эрдэс, боломжтой (C) зэргээр 22.996 мян.тн хүдэрт 56.22%-ийн дундаж агуулгатай 12.928 мян.тн эрдсийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байдаг.

Логийн хайлуур жоншны ордын I биетийн өмнөд хэсэгт 2009-2018 онуудын хооронд завсарлагатайгаар 45.973 мян.тн хүдэр, 55.96 %-ийн дундаж агуулгатай 25.673 мян.тн эрдэс олборлож, бодитой (B) зэргээр 1.863 мян.тн хүдэр, 55.82 %-ийн дундаж агуулгатай хүдэр, 1.040 мян.тн эрдэс, боломжтой (C) зэргээр 19.990 мян.тн хүдэр, 56.22 %-ийн дундаж агуулгатай 11.190 мян.тн эрдсийн нөөц үлдсэн (2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар) байдаг.

“Говь шоо” ХХК нь Логийн хайлуур жоншны ордын хүдрийн 1-р биетийн төв хэсэгт 2015-2018 онд 50x50 м-ийн нягтралтай хайгуулын тороор траншей нэвтрэлт, өрөмдлөгийн ажил явуулж 100-170 м хүртэлх гүнтэй нийт 1059 т.м бүгд 10 ширхэг цооног өрөмджээ. Нэвтэрсэн траншейн 26 м.куб, уулын ил малталтууд болон гүний өрөмдлөгийн цооногуудын хээрийн бичиглэлүүдийг хийж, тэдгээрийн урьдчилсан үр дүнгүүдийг ашиглан хайгуулын шугам тус бүрээр босоо зүсэлтүүд, ордын план зургийг 1:2000-ны масштабтай, сорьцлолтын план зураг (1:2000), баримт материалын зураг зохиосон, өрмийн малталтуудын хүдрийн биет огтолсон хэсгээс керний 96 ширхэг, траншейн ховилон сорьц 28 ширхэг дээж авч хайлуур жоншны агуулгыг тогтоосон ба хүдрийн баяжигдах шинж чанарын судлах зорилгоор дээж авч баяжуулах технологийн туршилт хийсэн байдаг.



Төслийн зорилго: Энэхүү төсөл хэрэгжсэнээр тухайн бүс нутагт аж үйлдвэржилт эрчимжиж түүнийг дагаад бусад жижиг дунд үйлдвэрлэл байгуулагдсанаар тухайн орон нутагт ажлын байр бий болохын зэрэгцээ, улсын төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлнэ.

Хүснэгт 2. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	"Говьшоо" ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011020042	
3	Уурхайн нэр	Логийн хайлуур жоншны далд уурхай	
4	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	Логийн хайлуур жоншны орд, MV-021536	
5	Анх батлагдсан геологийн нөөц	В=84.15 мян.тн /76.98 %/ С=98.48 мян.тн /65.79 %/	
6	Далд уурхайн хүрээн дэх геологийн нөөц	Хүдэр В+С= 101.92 мян.тн	Эрдэс (CaF ₂) В+С=77.581 мян.тн

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7	Олборлолтын үеийн хаягдал	16.50 %	
8	Олборлолтын үеийн бохирдол	10.83 %	
9	Үйлдвэрлэлийн нөөц	Хүдэр В+С=94.31 мян.тн	Эрдэс (CaF ₂) В+С=64.87 мян.тн
10	Ашиглах арга ба хугацаа	Далд уурхайн аргаар 3 жил	
11	Ашиглалтын систем	Хүдэр хоршоолон нураах	
12	Уурхайн хүчин чадал	40.0 мян.тн хүдэр	
13	Бүтээгдэхүүн гаргалт	ФК-75 – 33.48 мян.тн ФГ-85 – 22.13 мян.тн ФФ-95 – 18.6 мян.тн	
Далд уурхайн үндсэн үзүүлэлт:			
14	Босоо гол амны хөндлөн огтлолын талбай	$S_x=9.61 \text{ м}^2, S_r=7.1 \text{ м}^2$	
15	Хэвтээ малталтын хөндлөн огтлолын талбай	$S_r=6.5 \text{ м}^2$	
16	Босоо малталтын хөндлөн огтлолын талбай	$S=3.6 \text{ м}^2$ /восстающий/	
17	Үндсэн малталт нэвтрэлтийн урт	Урт - 296 м	
18	Бэлтгэл малталт нэвтрэлтийн урт	Урт - 695 м	
19	Далд уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	<ul style="list-style-type: none"> ✓ УТ-28 маркийн өрмийн машин ✓ ЛТРВ-1.2х1.2 маркийн өргөх төхөөрөмж ✓ Z-17AW маркийн ачигч машин ✓ УВО-0.8 маркийн тэргэнцэр ✓ ЦНС-38-154 маркийн усны шахуурга ✓ Агааржуулалтын сэнс, ВМЭ-6А /суурин/ ✓ Агааржуулалтын сэнс, ВОЭ-5 /зөөврийн/ ✓ 39WH-0.94/98 маркийн хийн шахуурга 	
20	Цахилгаан хангамж	10/0.4 кВ-ын трансформаторын дэд станц	
21	Засвар үйлчилгээ	Засвар механикийн цех	

Хүснэгт 3. Эдийн засгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Далд уурхай
			Нийт дүн /3 жил/
1	Төслийн нийт хөрөнгө оруулалт	сая төг	3233.86
2	Үүнээс анхны хөрөнгө оруулалт	сая төг	2431.11
3	Хүдэр олборлолт	мян.тн	94.31
4	Бүтээгдэхүүн гаргалт /ФК-75/	мян.тн	33.48
5	Бүтээгдэхүүн гаргалт /ФГ-85/	мян.тн	22.13
6	Бүтээгдэхүүн гаргалт /ФФ-95/	мян.тн	18.60
7	Бүтээгдэхүүн борлуулах үнэ, /ФК-75/	мян.төг/тн	495.01
8	Бүтээгдэхүүн борлуулах үнэ, /ФГ-85/	мян.төг/тн	561.00

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

9	Бүтээгдэхүүн борлуулах үнэ, /ФФ-95/	мян.төг/тн	705.10
10	Нийт борлуулалтын орлого	тэрбум төг	42.10
11	1 тн хүдэр олборлолтын үйлдвэрлэлийн өөрийн өртөг	мян.төг/тн	279.46
12	1 тн баяжмал үйлдвэрлэх бүрэн өөрийн өртөг	мян.төг/тн	355.19
13	Татварын өмнөх ашиг	тэрбум төг	15.74
14	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	сая төг	1843.70
15	Цэвэр ашиг	тэрбум төг	13.90
16	Төслийн шалгуур үзүүлэлтүүд		
	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	1.11
	Төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ NPV 10%	тэрбум төг	9.34
	Өгөөжийн дотоод норм - (IRR)	%	135 %
17	Уурхайн ажиллагсдын тоо /дунджаар/	хүн	83
18	1 ажилтны сарын дундаж цалин	мян.төг	2351.3
19	Нийт улс, орон нутгийн төсөвт оруулах татвар төлбөр	тэрбум төг	9.77
20	Үүнээс улсын төсөвт төлөх татвар төлбөр	тэрбум төг	7.89
21	Үүнээс орон нутгийн төсөвт төлөх татвар төлбөр	тэрбум төг	1.88
22	Татвар, төлбөрийн борлуулалтын орлогод эзлэх хувь	%	23.20

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Ордын анх батлагдсан геологийн нөөц

№	Геологийн нөөцийн зэрэг	Блокийн талбай	Дундаж зузаан	Блокийн эзлэхүүн	Эзлэхүүн жин	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц
		м ²	м	мян.м ³	тн/м ³	мян.тн	%	тн
1	1-В	1467.38	4.34	6.37	2.80	17.83	75.20	13409.36
2	2-В	1483.73	3.51	5.21	2.80	14.58	79.43	11582.56
3	3-В	1869.56	2.47	4.62	2.80	12.93	80.43	10399.50
4	4-В	1506.09	1.84	2.77	2.80	7.76	69.08	5360.18
5	5-В	405.72	3.51	1.42	2.80	3.99	70.44	2808.74
6	6-В	526.07	5.16	2.71	2.80	7.60	72.86	5537.84
7	7-В	1242.12	4.00	4.97	2.80	13.91	80.22	11160.00
8	8-В	1366.57	1.45	1.98	2.80	5.55	81.48	4520.73
9	1-С	371.80	3.81	1.42	2.80	3.97	78.24	3103.28
10	2-С	1247.14	3.88	4.84	2.80	13.55	83.72	11343.16
11	3-С	462.44	1.50	0.69	2.80	1.94	73.48	1427.16
12	4-С	4799.82	5.88	28.22	2.80	79.02	61.90	48916.00
13	1-Р	2142.15	6.97	14.93	2.80	41.81	61.81	25840.41
14	Дүн В	9867.24	3.05	30.05	2.80	84.15105	76.98	64778.91
15	Дүн С	6881.20	5.11	35.17	2.80	98.48178	65.79	64789.60
16	Нийт С+В	16748.44	3.89	65.23	2.80	182.63283	70.94	129568.51

1.3. Ашиглалтын системийн сонголт

Ашиглалтын системийг сонгохдоо баримтлах гол үндэслэл нь хүдрийн биетийн дундаж зузаан, хүдрийн биетийн уналын өнцөг, уул-геологийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх, хүдэр олборлолтын зардал хамгийн бага, хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр байх зэрэг юм.

Хүдрийн биетийн уналын өнцөг дунджаар 60°-70° градус, нөөц тогтоосон гүн нь ил уурхайн ёроолоос хамгийн ихдээ 115 м, хүдрийн биетийн дундаж зузаан нь 3.89 м байна. Геологи хайгуулын ажлаар тодорхойлогдсон хүдрийн биетийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн шпурын цэнэгийн аргаар хоршоолон нураах ашиглалтын системээр олборлоно.

Далд уурхайн ажиллах горим

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхайн ажиллах горимыг дараах байдлаар авч байна.

Үүнд:

- Жилийн нийт хоног

365 хоног

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Үндэсний баяр, ёслолын хоног 15 хоног
- Засвар үйлчилгээ, бусад 50 хоног
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног 300 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг тус тус байна.

Уурхайн календарь төлөвлөгөө

“Говьшоо” ХХК нь I хүдрийн биетийн хойд хэсэгт 2024 онд шинээр малталт нэвтрэлт, хүдэр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 5. Далд уурхайд дараах малталтуудыг нэвтрэнэ.

№	Малталтууд	Хөндлөн огтлолын талбай, м ²	Малталтын урт, м
1	Босоо гол ам	9.62	103
2	Квершлаг	6.5	90
3	Штрек	6.5	210
4	Восстающий	3.6	234

I хүдрийн биетийн далд уурхайгаас 22.95 мян.тн хүдэр хүдэр олборлоно.

Хүснэгт 6. Малталт нэвтрэлтийн ӨТА-н тооцоо

№	Үзүүлэлтүүд	Босоо гол ам	Квершлаг	Тээврийн штрек	Восстающий
1	Малталтын хөндлөн огтлолын талбай, м ²	9.62	6.5	6.5	3.6
2	Тэсрэх бодисын хувийн зарцуулалт, кг/м ³	2.2	2.6	2.6	3.5
3	Нийт шпурын тоо, шир	26	23	23	16
4	Үүнээс	Цөмлөх	4	4	4
5		Нураах	8	6	6
6		Хэв засах	14	13	13
7	Шпурын гүн, м	Цөмлөх	8	8	8
8		Нураах	14.4	10.8	10.8
9		Хэв засах	25.2	23.4	23.4
10		Нийт	47.6	42.2	42.2
11	Цэнэгийн жин, кг	Цөмлөх	6.0	6.0	6.0
12		Нураах	9.6	7.2	7.2
13		Хэв засах	16.8	15.6	15.6
14	Түгжээсний урт, м	Цөмлөх	2.00	2	2

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

15		Нураах	4.80	3.6	3.6	1.2
16		Хэв засах	8.40	7.8	7.8	6
17	Тэсрэх бодисын зарцуулалт, кг/цикл		32.4	28.8	28.8	20.4
18	Нураах уулын цулын хэмжээ, м ³		14.4	11.1	11.1	5.8
19	1 м шпурт ногдох уулын цулын хэмжээ, м ³ /м		0.3	0.3	0.3	0.2
20	1 м ³ уулын цулд ноогдох өрөмдлөгийн хэмжээ, м/м ³		3.3	3.8	3.8	5.1
21	Нийт уулын ажлын хэмжээ, м		103	90	210	234
22	Нэг мөчлөг дэх мөргөцөгийн ахилтын хэмжээ, м		1.50	1.70	1.70	1.6
23	Мөчлөгийн нийт тоо, удаа		69.0	53.0	124.0	146.0
24	Тэсрэх бодисын нийт зарцуулалт, тн		2.24	1.53	3.57	2.98

Хүснэгт 7. Малгалт нэвтрэлтийн ажилд хэрэглэх ТБ-ын зарцуулалт

№	Үзүүлэлтүүд	Босоо гол ам	Квершлаг	Тээврийн штрек	Восстающий	Нийт
1	Нийт өрөмдлөгийн урт, мян.м	3.28	2.24	5.23	4.32	15.08
2	Нийт тэсрэх бодисын зарцуулалт, тн	2.24	1.53	3.57	2.98	10.31
3	Нонель систем 5 м, шир	1794	1219	2852	2336	8201
4	Цахилгаан тэслүүр /ЭД/, шир	345	265	620	730	1960.0
5	Цочир дамжуулах шижим /ДША/, м	1380.0	1060.0	2480.0	2920.0	7840.0
6	Гал дамжуулах шижим /ОША/, м	8970.0	6095.0	14260.0	11680.0	41005.0
7	Бялт тэслүүр /КД/, шир	1794	1219	2852	2336	8201

Хүснэгт 8. Хүдэр нураалтын ӨТА-н тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Нураах үеийн дундаж өндөр	м	1.8
2	Нураах үеийн дундаж өргөн	м	1.8
3	Нураах үеийн хөндлөн огтлолын талбай	м ²	3.24
4	Шпурын диаметр	мм	42
5	Шпурын тоо	ш	12
6	1 шпурын урт	м	1.8
7	Өрөмдлөгийн нийт урт	м	21.6
8	Нэг шпур дэх цэнэгийн урт	м	1.2
9	Нийт цэнэгийн урт	м	14.4
10	Нэг удаагийн тэсэлгээнд орох ТБ-ын зарцуулалт	кг	14.4

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

11	Шпур ашиглалтын итгэлцүүр	-	0.89
12	ТБ-ын хувийн зарцуулалт	кг/м ³	2.78
13	Нэг цикл дэх мөргөцгийн ахилт	м	1.6
14	Нэг циклээс гарах уулын цулын хэмжээ	м ³	5.2
15	1 м ³ уулын цулд оногдох шпурын урт	м	4.17
16	1 м шпурээс гарах уулын цул	м ³	0.24
Нийт ордын хэмжээнд			
17	Нийт уулын ажлын хэмжээ	мян.м ³	8.1978
18	Мөчлөгийн нийт тоо	удаа	1581
19	Нийт өрөмдлөгийн хэмжээ	мян.м	34.1
20	Нийт ТБ-ын зарцуулалт	тн	22.8
21	ТБ-ын зарцуулалтын тооцооны норм	кг/м ³	2.78
22	Нонель	шир	18972
23	Цахилгаан тэслүүр /ЭД/	шир	7905
24	Цочир дамжуулах шижим /ДША/	м	31620
25	Гал дамжуулах шижим /ОША/	м	94860
26	Бялт тэслүүр	шир	18972

Хүснэгт 9. 2024 онд нийт зарцуулах ТМ-ын жагсаалт

№	Үзүүлэлтүүд	Малталт нэвтрэлт	Хүдэр олборлолт	Нийт
1	Нийт өрөмдлөгийн урт, мян.м	15.08	34.15	49.23
2	Нийт тэсрэх бодисын зарцуулалт, тн	10.31	22.77	33.08
3	Нонель систем 5 м, шир	8201	2.78	8204
4	Цахилгаан тэслүүр /ЭД/, шир	1960	18972	20932
5	Цочир дамжуулах шижим /ДША/, м	7840	7905	15745
6	Гал дамжуулах шижим /ОША/, м	41005	31620	72625
7	Бялт тэслүүр /КД/, шир	8201	94860	103061

БАЯЖУУЛАЛТ

Хүдрийн баяжигдах шинж чанарын судалгаа


“Говь шоо” ХХК-ийн Логийн хайлуур жоншны хүдрийн баяжигдах шинж чанарыг судлах зорилгоор 2017 онд ордын талбайгаас 265 кг сорьц авч уул уурхайн судалгаа шинжилгээний “Минлаб” ХХК-ийн лабораторид технологийн туршилт, шинжилгээг гүйцэтгүүлсэн байна.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Технологийн туршилтаар дээжид минераграф-петрограф-минералогийн болон бодисын найрлагын судалгаа хийж үр дүнд нь хүнд шингэнээр угаан баяжуулах туршилт, ангилан ялгалт-гравитаци-флотаци хосолсон туршилтуудыг хийж гүйцэтгэсэн. Туршилтын үр дүнд ФК-75, ФГ-85, ФФ-95 маркийн хайлуур жоншны баяжмал гарган авах боломжтой нь тогтоогдсон. Дээжийг туршилтад бэлтгэх уламжлалт аргачлалаар боловсруулж баялаг агуулгатай хүдрийг гар ялгалтаар ялгаж, гар ялгалтын хаягдал болон ядуу агуулгатай хүдрийг флотацийн аргаар баяжуулах технологийн туршилтыг хийж гүйцэтгэсэн байна.

Логийн хайлуур жоншны орд нь цахиуржсан флюоритын, бага карбонатлаг хүдэр бөгөөд голлох эрдэс нь фторт кальци байна. Хүдэр дэх хайлуур жоншны дундаж агуулга 60.84 %, карбонатын агуулга 1.21 % байна. Технологийн судалгаанд авчирсан дээжийн хайлуур жоншны агуулга нь 52.46-70.31 % хооронд хэлбэлзэх ба дундажлаж, хольсны дараа агуулга нь 60.84 % болсон байна.

Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн талбайн байршил



“Жонш баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн үйл ажиллагаанаас газрын хэвлийд дам байдлаар сөргөөр нөлөөлөх бөгөөд газрын гадаргын 2000-3000 м2 талбайд хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн барилгын ажлын үед 3000 м2 газрын гадаргад хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх боловч үйлдвэр баригдаж дууссанаар 2114 м2 хэмжээтэй газрын гадарга үйлдвэрийн барилгад дарагдахаар байна

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрийн хүдэр баяжуулах технологийн сонголт

Логийн хайлуур жоншны ордын туршилтын үр дүнд үндэслэн хүдрийг 3 төрлийн аргаар баяжуулахаар сонгосон.

1. Олборлосон хүдрийг баяжуулах төхөөрөмжид өгөхийн өмнө гар ялгалтаар бүхэллэг жоншийг ялгаж үлдсэн таваарын хүдрийг баяжуулах төхөөрөмжийн тэжээл болгон өгнө. Ордыг ашиглах хугацаанд 56.9 %-ийн хайлуур жоншны агуулгатай нийт 162.3 мян.тн хүдэр олборлон 1-р шатны бутлуураар бутлан ангилж ФК-75 маркийн 87.5 мян.тн металлургийн баяжмалыг гар аргаар ялган хэрэглэгчдэд нийлүүлнэ.

2. Үлдэх 35 %-ийн дундаж агуулгатай 74.8 мян.тн хүдрийг 2-р шатны бутлуурт бутлан 0-5 мм, 5-15 мм, 15-30 мм-ээр ангилан ялгаж үлдэх 5-15 мм болон 15-30 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг хүндийн хүчний аргаар баяжуулах төхөөрөмжид баяжуулан ФГ-85 маркийн баяжмал үйлдвэрлэнэ.

3. Нийт жоншны хүдрийн 54.04 хувийг эзэлж буй 0-5 мм-ийн ширхэглэлтэй болон тунаан баяжуулалтын хаягдал нь флотацийн үйлдвэрийн тэжээл болох юм. Энэ дунджаар 37.62 хувийн агуулгатай байна.

Хайлуур жоншны хүдрийг гравитаци, флотацийн аргаар баяжуулах технологийг сонгохдоо захиалагч талаас ирүүлсэн төслийн техникийн даалгавар болон Логийн хайлуур жоншны хүдрийг “Минлаб” ХХК-д боловсруулсан технологийн туршилтын тайлангийн үр дүн, санал зөвлөмжид тулгуурлан баяжуулах технологийг сонгон доор дурдсан технологийн ерөнхий шийдлүүдийг гаргасан байна.

Баяжуулах үйлдвэр нь хүдэр хүлээн авах талбай, бүхэллэг жоншийг гар аргаар ялгах хэсэг, хүдэр жигдрүүлэх талбай, бутлан ангилах хэсэг, гравитациар баяжуулах хэсэг, флотациар баяжуулах хэсэг, хаягдлын сан, эргэлтийн усны сан, хяналт шинжилгээний лаборатори, баяжмал ачих тээвэрлэх талбай зэргээс бүрдэнэ.

Хүснэгт 8. Технологийн ерөнхий шийдлүүд

✓ Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	- 40.0 мян.тн/жил - 190 тн/хоног - 10.6 тн/цаг - 210 хоног/жил - 5040 цаг/жил
✓ Бутлагдсан хүдрийн ширхэглэл	- 0-25 мм
✓ Анхдагч хүдэр дэх жоншны агуулга	- 56.9%
✓ Анхдагч хүдрийн нягт	- 2.8 гр/см ³
✓ Хүдэр бэлтгэх хэсэг	- 2 шатны бутлагч, 2 шатны шигшинг
✓ Хүдэр баяжуулах технологи	- 1 шатны тунаан баяжуулалт - 1 үндсэн флотаци - 6 шатны цэвэрлэгээний флотаци - 1 шатны хяналтын флотаци

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүдэр бутлалт

Анхдагч хүдрийг хяналтын шигшилттэй 2 шатны бутлалтын схемээр буталж хүдрийн ширхэглэлийг -25.0 мм болгоно. Нэгдүгээр шатны хацарт бутлуурын дээр байрлах бункерт өгөх хүдрийн ширхэглэл -400 мм байх бөгөөд бутлуураас -100 мм-ийн ширхэглэлтэй хүдэр гарна. Бутлагдсан хүдрээс ФК-75 маркийн бүхэллэг жоншийг гар аргаар ялгана. Хяналтын шигшилтийн зорилго нь бутлагдсан хүдрийн ширхэглэлд хяналт тавих болон хоёрдугаар шатны бутлуурт орох шаардлагагүй хүдрийг ялгана. Хяналтын шигшүүрийн торны нүхний хэмжээ 5, 10, 25 мм тус тус байна. Хяналтын шигшүүрийн торны дээрх +25 мм-ийн ангиллыг хоёрдугаар шатны хацарт бутлуурт өгнө. Шигшүүрээс гарах 0-5, 5-10, 10-25 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг ангилан овоолно.

Хүдэр нунтаглалт

Бутлагдсан хүдрийн агуулахаас туузан дамжуулагчаар тээвэрлэн ирэх 0-5 мм ширхэглэлтэй болон тунаан баяжуулалтын хаягдлыг -0.074 мм-ийн ширхэглэлийн ангиллыг 63-66% болгохын тулд нэг шатны нунтаглалттай схемийг хэрэглэсэн. Нунтаглалтад шүүрэн гаралттай GM1500*3600 маркийн бөмбөлөгт тээрэм хэрэглэхээр сонгов. Ангилалтад FLG-1200 маркийн мушгиа ангилагч хэрэглэх ба ангилагчийн нэмэх ангиллыг тээрэмд эргэлтийн ачаалал болгон өгнө.

Хүдэр баяжуулалт

Бутлан ангилах хэсгээс гарах 5-10 мм, 10-25 мм-ийн ширхэглэлтэй ангилсан хүдрийг тус тусад нь 1 шатны тунаах машинд баяжуулан ФГ-85 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэнэ. 0-5 мм-ийн ширхэглэлийн ангилал болон туналтаас гарсан хаягдлыг цааш флотацийн аргаар баяжуулах ФФ-95 маркийн жоншны баяжмалыг үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлнэ.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо


Баяжуулах үйлдвэр нь уурхайн ашиглалтын 1-р жилээс эхлэн нийт 5 жил ажиллах бөгөөд нийт 162.3 мян.тн хүдэр олборлон ФК-75 маркийн бүхэллэг баяжмалыг гар аргаар, 49.16 мян.тн хүдрийг тунаан баяжуулж, 0-5 мм-ийн ширхэглэлтэй болон тунаан баяжуулалтын хаягдал 87.7 мян.тн 37.62 %-ийн агуулгатай хүдрийг флотацийн аргаар баяжуулна. Тус үйлдвэрийн жилийн хүчин чадал 40.0 мян.тн ба баяжуулах үйлдвэр дулааны улиралд буюу 4-11 сар хүртэл 210 хоног ажиллахаар төлөвлөсөн. Үйлдвэрийн цагийн хүчин чадал 10.6 тн байна. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горимыг доорх хүснэгтэд үзүүлэв.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

№	Ажиллах горим	Хэмжих нэгж	Тоон хэмжээ
1	Жилд ажиллах бодит хоног	хоног	210
2	Жилд ажиллах бодит цаг	цаг	5040
3	Хоногт ажиллах бодит цаг	цаг	24
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
5	Ээлжид ажиллах бодит цаг	цаг	12
6	Техникийн ажлын норм	%	75
7	Цагийн хүчин чадал	тн/цаг	10.6
8	Хоногийн хүчин чадал	тн/хоног	190
9	Жилийн хүчин чадал	тн/жил	40000

Хүснэгт 11. Технологийн схем



Зураг 7. Технологийн схем

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж

“Говь шоо” ХХК-ийн баяжуулах үйлдвэрт ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 12. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Техникийн үзүүлэлт		Ажиллах тоо, ш	Чадал, кВт	
			Нэгж	Хүчин чадал		Нэгж	Нийт
1	Чичиргээт тэжээгүүр	GZT-0724	тн/цаг	36-90	/кВт/3	3	9
2	Туузан дамжуулагч	B-500	тн/цаг	20-120	8	4	32
3	Хацарт бутлуур	PE400*600	тн/цаг	15-60	1	30	30
4	Хацарт бутлуур	PE250*400	тн/цаг	25-55	1	15	15
5	Ангиллагч шигшүүр	3YA1530	тн/цаг	10.-80	1	7.5	7.5
6	Тунаах машин	XD4-2	тн/цаг	40-50	2	22	44
7	Хавтанг тэжээгч	Ø1000			1	1.5	1.5
8	Бөмбөлөгт тээрэм	GM1500*3600	тн/цаг	2.4-12	1	130	130
9	Мушгиа ангиуур	FLG12	тн/цаг	44-110	1	5.5	5.5
10	Урвалж холих чан	Ø1.5м RJ15	м ³	2.64	3	5.5	16.5
11	Урвалж холих чан	Ø1.0м RJ10	м ³	0.78	4	1.5	6
12	Автомат урвалж нэмэгч				2	0.5	1
13	Флотомашин	SF-2.8	м ³ /цаг	2.8	30	12.5	375
14	Тохируулагч хаалт				6	0.55	3.3
15	Баяжмал өтгөрүүлэгч	TNZ-9m	м	Ø9	1	3	3
16	Хаягдал өтгөрүүлэгч	TNZ-9m	м	Ø9	1	3	3
17	Вакуум филтр	GW20	тн/цаг	3-5.0	1	37	37
18	Хагаагуур	Ф1200*12000	тн/цаг	2-6.0	1	11	11
19	Даралтат филтр	XMZ200/1000U	тн/цаг	15-35	1	4	4
20	Ус халаагч	0.7MW	м ³ /цаг	80	2(1)	7.5	15
21	Эргэлтийн усны насос	3/2 C-AHR	м ³ /цаг	35	2	15	30
22	Эргэлтийн усны насос	IRG65-200A	м ³ /цаг	50	4	5.5	22
23	Булингын насос	80ZJY-435	м ³ /цаг		1	55	55
24	Булингын насос	80YZ50-20	м ³ /цаг	20-60	3(1)	30	90
25	Цахилгаан өөрөө өргөгч	LDA-5 L=18M, H=7M	тн	5	1	8.3	8.3
26	Цахилгаан өөрөө өргөгч	LDA-3 L=18M, H=7M	тн	3	1	1.7	1.7
27	Нийт						956.3


Хаягдлын аж ахуй

Логийн хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь хүдрийг флотацийн аргаар баяжуулан үйлдвэрээс гарах хаягдлыг TNZ-9 маркийн өтгөрүүлэгч болон даралтат шүүлтүүрээр дамжуулан усгүйжүүлж 18-20 %-ийн чийглэгтэй хуурай хаягдал гарна. Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг баяжуулах үйлдвэрээс зүүн урагшаа 600 м зайд ил уурхайн ухаш хүртэл автосамосвалаар тээвэрлэнэ.



Баяжуулах үйлдвэр





2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Урвалжийн хэсэг нь баяжуулах үйлдвэрийн үндсэн хэсгийн нэг бөгөөд түүний үйл ажиллагаа нь хүдэр баяжуулалтын технологид чухал нөлөө үзүүлдэг. Энэ хэсгийн гол зорилго нь технологийн процесст хэрэглэгдэж байгаа урвалжуудыг зохих технологийн дагуу уусгаж өгөгдсөн концентрацитай уусмал бэлтгэх, баяжуулах процессыг тасралтгүй хангах, урвалжууд болон уусмалуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврын дагуу хүлээн авах, уусгах, зөв хадгалах юм.

- Тохируулагч урвалж – Техникийн сод (Na_2CO_3)
- Дарагч урвалж – Шингэн шил (Na_2SiO_3)
- Цуглуулагч урвалж – Тосны хүчил ($\text{C}_{17}\text{H}_{33}\text{COOH}$)

Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахад үйлдвэрийн 20 хоногийн хэрэглээнээс доошгүй хэмжээний нөөцтэй байна. Химийн бодисын агуулахад нөөцлөгдөх хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 13. Урвалж бодисын зайлшгүй байх нөөц

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Тосны хүчил	тн	4.0
2	Техникийн сод	тн	5.5
3	Шингэн шил	тн	3.0
4	Декстрин	тн	1.8

Хүснэгт 14. Флотацийн процесст хэрэглэгдэх урвалжийн зарцуулалт

№	Үйлдлийн нэр	Урвалжийн зарцуулалт, гр/тн			
		Тосны хүчил	Техникийн сод	Шингэн шил	Декстрин
	Урвалж бодисын химийн томьёо	$\text{C}_{18}\text{H}_{34}\text{O}_2$	Na_2CO_3	Na_2SiO_2	$(\text{C}_6\text{H}_{10}\text{O}_5)_n$
	Урвалжийн зориулалт	Цуглуулагч	Орчин тохируулагч	Дарагч	Дарагч
1	Анхан шатны хөвүүлэн баяжуулалт	800	1600	400	-
2	I шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	100	-	150	-
3	II шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	75	-	75	-
4	III шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	50	-	50	-
5	IV шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	-	-	-	150

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	V шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	-	-	-	100
7	VI шатны цэвэрлэгээний хөвүүлэн баяжуулалт	-	-	-	-
8	I шатны хяналтын хөөсөн баяжуулалт	200	150	200	50
9	Нийт зарцуулалт	1225	1750	875	300

1.4. 2024 уулын ажлын төлөвлөгөө

Далд уурхайн үндсэн /босоо гол ам, квершлаг/ ба бэлтгэл /штрек/ малталтыг хоосон чулуулаг дундуур нэвтрэх тул ямар нэгэн нөөцийн блокт хамааруулах боломжгүй юм. Босоо гол амыг хүдрийн биетийн хэвтээ талд газрын гадарга дээрх хүдрийн биетийн гаршаас 25 м зайд хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Харин тээврийн штрекийг ашиглалтын түвшин бүрт хүдрийн биетийн хэвтээ контактаас 5 м зайд хүдрийн биеттэй параллелиар хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Харин квершлаг малталтыг босоо гол амнаас тээврийн штрек малталтад перпиндикуляраар хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Малталтаас гарах хоосон чулуулгийн хэмжээ:

- Босоо гол амыг $S=9.62 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 103 м малталт нэвтрэнэ. $V=s*l=9.6*103=990 \text{ м}^3$
- Квершлаг малталтыг $S=6.5 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 90 м малталт нэвтрэнэ. $V=s*l=6.5*90=585 \text{ м}^3$
- Штрек малталтыг $S=6.5 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 210 м малталт нэвтрэнэ. $V=s*l=6.5*210=1365 \text{ м}^3$

Малталт нэвтрэлтийн ажлаас нийт $990+585+1365= 2940\text{м}^3$ хөрс гарна.

Олборлолт

“Говьшоо” ХХК нь I хүдрийн биетийн хойд хэсэгт 2024 онд шинээр малталт нэвтрэлт, хүдэр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 15. Далд уурхайд дараах малталтуудыг нэвтрэнэ.

№	Малталтууд	Хөндлөн огтлолын талбай, м^2	Малталтын урт, м
1	Босоо гол ам	9.62	103
2	Квершлаг	6.5	90
3	Штрек	6.5	210
4	Восстающий	3.6	234

I хүдрийн биетийн далд уурхайгаас 22.95 мян.тн хүдэр хүдэр олборлоно.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Баяжуулалт: Уурхайгаас олборлосон хүдрээс эхлээд гар аргаар ялгалт явуулан ФК-75 маркийн бүхэллэг баяжмалыг ялган авч үлдэгдэл хүдрийг гравитаци болон флотацийн аргаар баяжуулан ФГ-85, ФФ-95 маркийн баяжмал гарган авна. 2023 онд ФФ-95 маркийн 4.59 мян.тн, ФГ-85 маркийн 5.60 мян.тн, ФК-75 маркийн 8.26 мян.тн баяжмал гарган авна.

Эдийн засаг: 2023 онд уурхайд 70-н ажилтан ажиллана. ФФ-95, ФГ-85 ба ФК-75 маркийн баяжмалыг БНХАУ-д борлуулна. 2023 онд нийт 9352.355 сая.төг-ийн борлуулалт хийж 6751.79 сая.төг-ийн зардал гарган ажиллана.

1.5. ДЭД БҮТЭЦ

Цахилгаан эрчим хүчний үүсгэвэр

Уурхай болон ажилчдын тосгоны цахилгаан хэрэглэгчдийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын төвөөс уурхай хүртэл 20 км өөрийн хөрөнгөөр татсан 10 кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаас цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Түлш дулаан хангамж

Тус далд уурхай нь 2024 онд 300 хоног ажиллах ба өвлийн улиралд ажиллагсдын тосгон, уурхайн захиргаа болон засварын газар зэрэг барилга байгууламжийг нам даралтын бага оврын уурын зуухаар дулаанаар хангана.

Уурын зуухны ажиллах сар нь 10-р сарын 15-аас 5-р сар хүртэл буюу 6 сарын хугацаанд ажиллана. Уурын зуухны сарын хэрэглээнд 10 тн нүүрс түлэх шаардлагатай гэж үзвэл 6 сарын хугацаанд 60 тн нүүрс хэрэглэнэ. Шаардлагатай нүүрсийг Хөөтийн нүүрсний уурхайгаас худалдаж авна.

Сэлбэг материалын агуулах

Тус уурхайн тэсрэх материалын агуулах нь уурхайгаас зүүн урагш 1.3 км зайд байрлана. Тэсрэх бодис хадгалах 20 тоннын багтаамжтай 1 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 20 тоннын 1 ширхэг контейнер агуулах тус тус байна.

Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн агуулахыг 20 тоннын багтаамжтай контейнер ашиглан байгуулсан. Шатах тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн уурхайн тосгоны баруун урд талд үйлдвэрлэлийн талбайд баригдсан. Энд 20-40 тн багтаамжтай төмөр торхтой тослогооны материал, уурхайн 30 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний багтаамж бүхий ёмкость байрлана.

Зам тээвэр, харилцаа холбоо

Тус орд нь ойролцоох сум суурин газруудтай ердийн хээрийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд нь байнгын усалгаа арчилгаатай уурхайн зориулалттай сайжруулсан шороон зам байна.

Гадаад тээвэр

Тус уурхайгаас олборлосон хүдрээс ФК-75, ФГ-85, ФФ-95 маркийн баяжмал үйлдвэрлэн автомашин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгаж байна.

Зураг- 1. Лог - Баянжаргалан чиглэлийн сайжруулсан шороон зам



Зураг- 2. Хөөт – Олон-Овоот өртөө чиглэлийн сайжруулсан шороон зам




Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Говьшоо” ХХК-ийн Логийн уурхай, “Үнэн-Анд” ХХК-ийн Мануултын уурхай, “Аргатай” ХХК-ийн Улаан толгойн уурхай, “Монголросцветмет” ХХК-ийн Хөх дэлийн хайлуур жоншны уурхай, “Болор жонш” ХХК-ийн Зүүн Аргатайн уурхайнууд нийлэн гадаад тээврийн олон салаа зам гарахаас сэргийлэх, гадаад тээврийн тогтсон нэг маршруттай болох зорилгоор замыг засаж сайжруулсан. Логийн хайлуур жоншны уурхайгаас Баянжаргалан сумын урдуур өнгөрөх Хөөт-Олон-Овоот өртөө /25-р зөрлөг/ хоорондох сайжруулсан шороон зам хүртэл 31 км замыг засаж сайжруулсан.

Авто тээвэр: Логийн хайлуур жоншны далд уурхайгаас Баянжаргалан сум, төмөр замын Олон-Овоот өртөө гэсэн маршрутаар нийт 100 км шороон замаар тээвэрлэнэ.

Төмөр замын тээвэр: Олон-Овоот өртөөнөөс улсын урд хил хүртэл 370 км төмөр замаар тээвэрлэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг- 3. Гадаад тээврийн замын зураг



Хүснэгт 16. Тээвэрлэх ачааны хэмжээ

№	Ашиглалтын жилүүд	ФК-75, мян.тн	ФГ-85, мян.тн	ФФ-95, мян.тн
1	2023 онд	8.263	5.6	4.5908

2023 онд нийт 1.6 мян.м³ хөрсийг дотоод овоолгол хурааж 0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал

Дундговь аймгийн цаг уурын станцуудын ажиглагдсан мэдээнээс үзвэл сүүлийн 20 жилийн агаарын дундаж температур нь 3.0°C бөгөөд 1.4-4.7 хэмийн хооронд хэлбэлзэж байна. улирлаар авч үзвэл өвлийн дундаж температур нь -15.7 хэм бөгөөд -11.9 -аас -19.1 хэмийн хооронд, зуны дундаж температур нь 20.0 хэм бөгөөд 18.4 - 21.9 хэмийн хооронд хэлбэлзэж байна. агаарын дундаж температур нь 2007 онд хамгийн дулаан, 2012 онд хамгийн хүйтэн байсан бол бусад жилүүд нь дундажтай ойролцоо байна. агаарын үнэмлэхүй хамгийн бага температур 2002 онд сайхан-овоо өртөөнд -41.0 хэм байсан бол үнэмлэхүй хамгийн их температур 2017 онд Баянжаргалан өртөөнд 41.0 хэм хүрчээ (badamsuren, 2022). хаврын улиралд 0 хэмээс дээш халах үе 3-р сарын сүүлийн арав хоногт тохиодог байна. хөлдөх температуртай өдрүүдийн эхлэх хугацаа нь 10-р сарын сүүлийн арав хоногт байдаг. олон жилийн дунджаар 0-ээс дээш хэмтэй хоногийн тоо 210 хоног, харин 0-ээс доош хэмтэй өдрийн тоо 156 хоног байна. зуны өдөр буюу хамгийн их температур 25 хэмээс дээш байх өдрийн тоо 4-р сараас эхэлж 10-р сар хүртэл үргэлжилдэг байна (monthly aggregated climate dataset, 2022).

агаарын жилийн дундаж температур 2.9-6.0 хэмийн хооронд хэлбэлзсэн байв. энэхүү хэлбэлзлийг задлан үзвэл 1999-2007 онд аажмаар нэмэгдэж, дээд тал нь 6.0 хэм хүрч, 2007-2012 онд аажмаар буурч хамгийн багадаа 2.9 хэм хүрсний дараа 2017 онд өссөн бөгөөд өгсөх буурах хандлага 1-3 жил тутамд өөрчлөгдсөн байна (badamsuren, 2022).

Дундговь аймагт дунджаар 120 мм хур тунадас унадаг байна. Сүүлийн 20 жилийн мэдээгээр Мандалговьд 84.6-188.0 мм, сайхан-овоод 25.7-222.2 мм, Эрдэнэдалайд 68.5-241.1 мм, Баянжаргаланд 46.5-195.1 мм хур тунадас оржээ (monthly aggregated climate dataset, 2022).

2.3. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал

“Говь шоо” ХХК-ийн “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын хэмжээг доорх хүснэгтээр үзүүлэв. Тус төслийн MV-017543 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэмжээ нь 48.24 га байна.

“Говь шоо” ХХК нь “MV-017543” дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлөөс гадна хил залгаа орших “MV-021536” мөн эзэмшдэг байна. MV-021536 талбай нь сүүлд хайгуул хийгдэн нөөц нь батлагдаж ашиглалтад шилжсэн болно. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн дэргэд 4802000646 нэгж талбарын дугаар бүхий 11.2 га талбайтай газрыг Дундговь аймгийн Баянжаргалан сумаас олгосон эзэмших эрхийн гэрчилгээгээр уурхайн тосгон, баяжуулах

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

үйлдвэр зэрэг зориулалтаар ашиглаж байна. “Говь шоо” ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд болон газрын кадастрын зургийг дор үзүүлэв

Төслийн үйл ажиллагааны зүгээс газрын гадаргад нийт 18.6 га талбайд гол сөрөг нөлөөллийг үзүүлсэн байна. Доорх зурагт газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг эрчмээр зураглан үзүүлэв. Логийн хайлуур жоншны ордын хүрээнд 2015-2018 онд хайгуулын болон бусад үйл ажиллагаанаас үүдэн 3.0 га талбайд ил уурхай, 7.9 га талбайд овоолго үүссэн байна. Өнөөгийн байдлаар, ил уурхайн урт 650 м, өргөн 25-75 м, дундаж гүн ойролцоогоор 10-35 м байна.

“Говь шоо” ХХК нь 2006-2008 онд Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн дээд хэсэгт нөөц тогтоон 2008-2018 оны ил уурхайн аргаар олборлох ашиглалтын үйл ажиллагаа явуулсан. Харин 2015 оноос ордын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хайгуулын ажил хийж ил уурхайн ёроолоос хамгийн гүндээ 130 м-ийн гүнд нөөц тогтоосон.

Ордыг цаашид ил уурхайн аргаар ашиглахад хүндрэлтэй /хөрс хуулалт ихтэй/ болсон тул далд уурхайн аргаар ашиглахаар төлөвлөж байна. I хүдрийн биетийг нээх олборлох зорилгоор ил уурхайн зүүн талд газрын гадаргын $Y=724129.6$ $X=5051103.4$ солбицлын 1221 м-ийн түвшнээс 1092 м-ийн түвшин хүртэл 129 м босоо малталт тус нэвтэрнэ.

Тус төслийн талбайд 2006 оноос эхлэн уурхайн бэлтгэл ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд: ил ба далд уурхайн нээлт болон барилга байгууламж, тоног төхөөрөмж, шаардлагатай дэд бүтцийн ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэгдсэн байна.

Ордын геологийн нөхцөл

Логийн хайлуур жоншны ордын талбай нь Дундговийн гүдэн өргөгдлийн зүүн хойд хэсэгт, Баянжаргалангийн мезозой ба кайнозойн депрессийн зүүн урд орших ба зүүн хойш болон баруун хойш чиглэлтэй, томоохон систем хагарлаар хэрчигдэж нийлмэл блоклог тогтоцтой болсон бөгөөд баруун хойд, урд зүүн хэсгээрээ Хөөт, Чойрын хотгортой хиллэдэг. Геологийн тогтцын хувьд тухайн талбайд дээд протерозой, перм, юра болон цэрдийн насны тунамал, хувирмал хурдас тархах бөгөөд түүрүү палеозой ба триас, юрагийн интрузив бүрдэл болон олон тооны дэл, судлын чулуулаг өргөн тархалттай.


Хүдрийн биетүүдийг хүдэржилтийн төрөл, хүдрийн технологийн шинж чанараар нь:

- Нийлмэл тогтоцтой карбонат -кварц-хайлуур жоншны хүдэр;
- Энгийн судал хэлбэрийн кварц-хайлуур жоншны хүдэр гэсэн үндсэн хоёр төрөлд хуваадаг.

Логийн хүдрийн биет нь хүдэржилт болон хүдрийн технологийн шинжээр 1-р төрөлд хамаарна. Тус ордыг цаашид далд уурхайн аргаар ашиглахаар төлөвлөсөн байна. Далд уурхайн төлөвлөсөн гол амуудын байршлыг доорх зурагт үзүүлэв

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


Зураг- 4. Далд уурхайн төлөвлөсөн гол амуудын байршил



2.4. Төслийн талбайн гадаргын болон газрын доорх усны төлөв байдал

Төслийн талбай болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөхөөр гадаргын ус байхгүй болно. “Говь шоо” ХХК-ийн “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл (MV-017543)”-ийн талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газарт тус тус багтана. Тухайн районд гадаргын усан сүлжээ хөгжөөгүй байна. Уурхайн эдэлбэр газрын орчимд гадаргын ил урсгалтай усгүй зөвхөн зуны улиралд түр зуурын тогтоол нуур болон хоолойг дагаж урсац үүсэх боловч тэдгээр нь уурхайд ус үерийн нөлөөлөл үүсгэхгүй юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Мөн зүүн хойд зүгт Баянцогтын говьд давстай ус бүхий Их улаан нуур (1100.0 м) байна. Төслийн талбайн эргэн тойронд 5-9 км зайд хэд хэдэн нэргүй тойром байна.

“Говь шоо” ХХК нь Логийн хайлуур жоншны ордыг ашиглах төслийн (MV-017543) талбайг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 2.1-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолын Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай тус тус давхцалгүй гэсэн лавлагааг БОАЖЯ-ны Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын мэдээллийн сангаас цахим лавлагаа авсан байна.

Логийн хайлуур жоншны ордын талбай нь газар зүйн байрлалын хувьд говийн мужийн хойд хилтэй хиллэх зааг орчмын говь хээрийн бүсийн завсрын шинж төрхийг бүрдүүлсэн намхавтар уул толгодын бүсэд байрлах ба тэдгээрийн жижиг хөндийнүүдийг ухаа гүвээт талууд хүрээлж оршино. Энэхүү сав газарт ашиглах бололцоотой газар доорх усны нөөц гэдэг нь олон жилийн туршид хуримтлагдсан нөхөн тэжээгддэггүй газар доорх усны нөөцөөс бүрддэг болно. Энэхүү Логийн ордын газрын доорх ус нь гидрогеологийн мужлалын 3-р эрэмбийн жижиг толгод бүхий массивд хуримтлагдсан ба үндсэндээ Монгол орны говийн бүсэд оршдог учраас энд жилд унах хур тунадас багавтар бөгөөд ууршилт нь унах хур тунадаснаас давдаг байна.

Үндсэндээ тал хээрийн бүсэд оршдог учраас уулс хоорондын аллюви, пролювийн гаралтай сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст давхаргад 5 мм/жил.км², уулс толгодыг бүрдүүлэгч үндсэн

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

чулуулгийн ан цавын уст бүрдэлд 10-20 мм/жил.км² хэмжээтэй нөхөн сэргээгдэх нөөц тархсан байна (Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл, нэгдүгээр дэвтэр, хуудас 456-466, Н.Жадамбаа нар.)

Судалгааны талбайн газар доорх усны хэмжилт судалгаа

Хайлуур жоншны ордын хэмжээнд тархсан мезо-палеозойн настай гүний болон бялхмал чулуулгийн ан цавын уст бүрдлийн усжилтын мэдээллийг тодорхойлохын тулд дараах төрлийн гидрогеологийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тухайн талбайд өмнөх судлаачдын хийсэн геологи-гидрогеологийн маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж, уулын далд малталтын босоо аманд гидрогеологийн шавхалт туршилтын ажлыг явуулсан. Гидрогеологийн шавхалт туршилтын ажлыг явуулснаар ордын гидрогеологийн нөхцөл болон геологийн зүсэлтийн гүний бүтцийг тоймлон судалж тогтоох, геологийн зүсэлт дэх чулуулгийн усжилтыг тодорхойлох зорилгоор гидрогеологийн ажиглалт, хэмжилт судалгааны ажлыг далд уурхайн босоо аманд гүйцэтгэсэн.

Гидрогеологийн шавхалтын ажлыг далд уурхайн босоо аманд ус өргөгч насосыг 40.0 м гүнд ус хуримтлуулах зориулалттай зумпфэнд суулган явуулсан. Тухайн босоо аманд ус хуримтлуулан зайлуулах зорилгоор бэлтгэсэн зумпфэний багтаамж ойролцоогоор 6 м³ орчим бөгөөд уг зумпфэнд хуримтлагдсан усыг цагт 12 м³ ус татах хүчин чадалтай насосоор 30 минутад шавхаж зайлуулж дуусгасан ба энэхүү зумпфнээс усыг шавхаж дууссаны дараа 4-5 цагийн дараа ахин дүүрч байсан. Шавхалтын ажлын мэдээллээр дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:

- Гидрогеологийн шавхалтын ажлын үр дүнд тухайн босоо амны усжилтын мэдээлэл болох газрын доорх урсцын хэмжээг бодиттойгоор тогтоосон. Босоо ам бүхий уулын далд малталтад орж ирж буй газрын доорх усны урсац цуглуулж буй 6 м³ буюу 6000 л орчим багтаамжтай зумпф нь 4 цагийн дараа дүүрч байгаагаас үндэслэн далд малталтад орж ирж буй усны хэмжээ нь ойролцоогоор 0.42 л/сек буюу хоногт 36.3 м³ хэмжээтэй ус шүүрэн орж байгааг тогтоосон.
- Энэхүү шавхалт туршилтын ажлын үр дүнгээр тухайн ордын хэмжээнд тархсан гүний болон бялхмал чулуулгийн ан цавын уст бүрдлийн тооцооны үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн.

Ордын гидрогеологийн нөхцөл

Судалгааны талбайн хэмжээнд геологийн давхарга зүйн ангиллын дагуу газар доорх усны байрлал, хөдөлгөөн, хуримтлагдах нөхцөл, геологи-литологийн бүтэц, тогтоц зэргийг харгалзан дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдасны нүх сүвийн ус агуулсан уст давхарга, доод цэрдийн настай цагаан цавын давхаргасны бялхмал чулуулгийн ан цав-давхраасны ус агуулсан уст давхарга, мезозой-палеозойн настай гүний болон бялхмал гарал үүсэлтэй чулуулгийн ан цавын уст бүрдлүүдийг ялгасан. Судалгааны талбайн хэмжээнд нүх сүвийн, нүх сүв-давхраас, ан цав судлын коллекторт агуулагдсан үндсэн 3 төрлийн ус агуулагч үе, давхарга, уст бүрдэл тархсан байна.

Тухайн сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийг ерөнхийлөн нэгтгэж, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, нүх сүв-давхраас зонхилсон, эсвэл ан цав зонхилсон байдлаар нь ангилж, газар доорх усны судлагдсан түвшин, хөдөлгөөний төрхийг харгалзан гидрогеологийн давхарга зүйн ангиллыг хийж, ангилал тус бүрийн газар доорх усны

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

бүрэлдэх зүй тогтол, усны чанар, хөдөлгөөний талаар хайлуур жоншны ордын хэмжээнд товч дурдан бичлээ.

Гидрогеологийн массив буюу тэжээгдлийн гадаад мужид агаарын хур тунадас буух нь илүү, хоногийн температурын зөрүү их учир чулуулгууд физик өгөршилд амархан орж өгөршил бутралын бүсийг үүсгэх ба энэхүү идэвхтэй ан цавын бүсээр агаарын хур тунадасны чөлөөт нэвчилт идэвхтэй явагдаж, ан цавын усажсан бүсийн газар доорх усны нөөц баялгийг байнга нөхөн сэлбэх замаар далд уурхайд орох газар доорх усны урсцыг нэмэгдүүлнэ.

Хайлуур жоншны орд нь мезо-палеозойн үед үүссэн гүний чулуулаг нөгөө талаас суурилаг найрлагатай бялхмал чулуулгуудын хил зааг орчмоор тектоникийн суларсан бүс дагаж судал маягаар үүсэн бүрэлдсэн байна. Ордын агуулж буй чулуулгууд нь янз бүрийн гүн (гол төлөв 40-120 м хүртэл) нэлээд өгөршилд автагдаж, ан цавшил ихтэй болсон байна.

Энэ ордын хэмжээнд тархсан газар доорх ус нь ан цавын, ан цав-судлын төрөлд хамаарагдах ба ан цав хагарлын бүсээр болон хуурай сайр, жалгын дагуух хөндийнүүдээр агаарын хур тунадасны нэвчилтээр газар доорх усны үндсэн тэжээл бүрдэнэ. Ордын газар доорх усны харьцангуй өндөр усжилттай хуримтлал нь тектоникийн хагарлуудын бүсэд тохиолдоно. Эдгээр нь хайгуулын үед өрөмдөгдсөн гидрогеологийн цооногуудын үр дүнгээс тодорхой харагдах ба энд цооногийн ундарга нь 1.5 -10.5 м түвшний бууралтад 0.5-1.0 л/с байжээ. Харин хайлуур жоншны ордын олон жилийн ашиглалтын явцад уурхайгаас их хэмжээний ус зайлуулсантай холбоотойгоор ордод агуулагдаж буй газар доорх усны нөөц баялаг багасаж, усны түвшингийн бууралтын нөлөөллийн радиус тэлэх учир уст давхаргын тооцооны параметрууд гүн рүүгээ болон талбайн хэмжээнд өөрчлөгдөх болно.

Усны статик түвшин 20.0 м-ийн гунд байрлаж, усны эрдэжилт 0.6-0.9 г/л байна. Гагцхүү уулын далд малталтуудаар олон жилийн турш хүдэр олборлох явцад энэ ордын гидрогеологийн нөхцөл болон уст давхаргын усжилтын параметрууд үндсэндээ өөрчлөгдөж, геологийн ба хүрээлэн буй орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх гидродинамикийн бодит нөхцөл бий болно гэж үзэж байна. Зуны хур бороо элбэг үед энд усны түвшин 0.6-1.5 м хүртэл дээшилдэг. Бусад үед тогтвортой түвшинд байрладаг гэж үзэж байна.

Тус ордын хүдрийн 1-р биетийн өмнөд хэсэгт хэвтээ малталтаар олборлолт явуулж, 2018 оны эцсээр хийсэн геодезийн хэмжилтээр 30 м гүнтэй босоо амаар уурхайлсан бөгөөд үндсэн 3-р босоо аманд 28 м-ээс штрекийн уланд ус шүүрч эхэлсэн тухай тэмдэглэжээ.

Уурхай дахь хүдрийн биет нь зүүн хойноос баруун урагш чиглэлтэй тектоник хагарлаар зааглагдан сунаж тогтсон ба хагарал, сулралын бүсэд палеозойн настай гүний чулуулгийн ан цав, үе давхаргын ус агуулагч бүрдлийн тархалтын талбайд байрлана. Одоогийн байдлаар штрекийн ул хэсэгт уст давхарга тогтсон байна. Уст давхаргын толин гадаргын өндөржилт ойролцоогоор 1180 м, гүн 3-4 м хүрчээ.

Уурхайн штрект палеозойн настай гүний чулуулгийн уст бүрдлийн ан цавын ус нэвчих бөгөөд нүх сүвний мэшил, уст давхаргын тархалтын талбай дахь усны хөдөлгөөний чиглэл судлын биетийг дайрч өнгөрдөг учир ашиглалтын явцад уурхайн усжилтад шууд нөлөөлөх болно. Уст давхаргын ан цавын тархалтын гүнийг судалж тогтоосон зүйл байхгүй боловч судалгааны районд Чойрын экспедицийн явуулсан судалгаанд дурдсанаар гүний чулуулгуудын ан цавжсан гүн нь усан хагалбараас (10-15 м) бэл рүүгээ (80-100 м) ихэсдэг байна.

Уурхайн 3-р босоо аман дахь усжилтын ус агуулагч палеозойн ан цавын уст бүрдэл нь 4 м түвшин бууралтад 3.0 л/с ундаргатай, усны тогтонги түвшин 30 м болохыг тогтоосон байдаг.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Одоогийн байдлаар босоо амны амсрыг сайн битүүмжилсэн байдалтай, худгийн амсрын өндөржилт -1182.7 м, солбицол: 724077.81-5051193.27, усны түвшний өндөршил 1180 м, босоо амны амсар цантсан, хөлддөггүй гэсэн байдаг.

2016, 2018 онуудад 1-р биетийн хойд хэсэгт хийгдсэн өрөмдлөгийн ажлаар ямар нэгэн уст үе илрээгүй.

Судалгааны үр дүнгээр доорх дүгнэлтийг гаргаж болно. Үүнд:

Уст давхаргын ан цавын тархалт районы хэмжээнд 100 м-ийн гүнээс багасаж нягт бүтэцтэй болдог ба анх ус шүүрэлт эхлэх үеийн уурхайн малталтын гүн 30 м байсан. Өмнөх судалгааны дүнгээр уурхайн хэвтээ малталтын улнаас шүүрэх усны хэмжээ 0.6 л/с-ээс ихгүй гэсэн байдаг. Гидрогеологийн нөхцөлийг нь бодолцож үзвэл газрын доорх усны тэжээлийн талбай ба нэвчилтээр орох усны хэмжээ бага байх магадлалтай байгаа тул ус өгөмж, шүүрлийн илтгэлцүүрийг чулуулгийн шинж чанарыг харгалзан тооцоонд авах боломжтой.

Тус ордын уурхайд шүүрэн орох усны хэмжээ түүнд агуулагдах статик нөөц болон түвшин доошлохын хирээр гадаад орчноос нэвчин орох динамик нөөцийн хэмжээнээс шалтгаална. Балансын аргаар усны нөөцийн үнэлгээ өгч болох боловч түвшин бууралт, цооногийн боломжит хүчин чадлыг тодорхойлох боломжгүй.

Энэ ордын хувьд газрын доорх усны эх үүсвэр нь зөвхөн хур тунадасны нэвчилтийн ус байна. Тухайн талбайд орох хур тунадасны хэмжээ Баянжаргалан сумын цаг-уурын станцын сүүлийн олон жилийн дунджаар 130 мм байдаг.

Ордын уурхайн хамгийн их усжилтын хэмжээ 1.5 м³/ц-аас хэтрэхгүй, түүний дээр хур бороо, үерийн эрсдэл багатай нөхцөлтэй гэдэг нь өмнөх жилүүдийн ашиглалтын явцад тогтоогдсон. Уурхайгаас ус зайлуулах насос нь хүчин чадлын хувьд 12 м³/цаг байхад хүрэлцээтэй байна. Уурхайгаас зайлуулах усыг уулын малталтын хилийн гаднаас тооцох нөлөөллийн радиус R1 буюу 300 м-ээс бага зайд байрлуулж болохгүй.

Уурхайн малталтад ажиглагдаж байгаа хагарал нь бие даасан ус агуулсан бүтэц гэж харагдахгүй байгаа боловч цаашид анхаарах шаардлагатай байгаа юм.

2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал:

Цайвар хүрэн хөрс. Цөлөрхөг хээрийн бүсийн хойд хэсэгт үетэн-монгол өвст бүлгэмдэл голлож агь, сонгино, харгана нэлээн холилдсон газраар тархах бөгөөд ургамлын бүрхэц 20-30%-иас орчим байдаг. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг. Ялзмаг хуримтлалын давхарга (А) нь цайвар хүрэн өнгөтэй, бүдэг бөөмөрхөг бүтэцтэй, үе давхарга нэлээд тод илэрсэн, зузаан нь дунджаар 10 см байна. Түүний доорх арай нягтавтарт шинжтэй, бага зэрэг ялзмагжсан, боровтор өнгөтэй В1 давхарга ихэнх тохиолдолд ялгарч харагдах бөгөөд давсны хүчилд бургих гүн янз бүр байна. Цайвар хүрэн хөрсний ялзмаг хуримтлалын давхарга дахь органик бодисын хэмжээ 1-2% орчим байх ба ялзмагийн найрлага дахь гуминийн хүчил, фульво хүчлийн хэмжээ ойролцоо (Сгх:Сфх=0.9-1) байна. Урвалын орчин хөрсний бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй, ялангуяа доод давхаргуудад илүү шүлтлэг байна. шингээх чадвар бага (100 гр хөрсөнд 9-15 мг/экв) солилцоот катионуудын найрлагад натри ион маш бага хувийг эзэлнэ. Өвөл 2.5-3 м хүртэл гүн хөлдөнө. Зуны хур борооны ус

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж хөрсний профилийн дээд хэсгийг чийглэдэг. Үржил шимээр тааруухан, шим тэжээлийн бодисын хангамж бага байна. Хөрсний дээд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 30-40 тн/га, бүх азотын нөөц 3 тн/га орчим байдаг. Энэ хөрс бэлчээрийн эдэлбэр газрыг бий болгох бөгөөд зөвхөн усалгаатай нөхцөлд тариаланд ашиглах боломжтой.

Хөрсний хими, физик шинж чанар:

“Говь шоо” ХХК-ийн “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн талбайн орчимд тархсан хөрсний хими шинж чанарыг үзсэн.

Хөрс нь шүлтлэг урвалын (рН) орчинтой, GSh-07 зүсэлтийн 15-40 см, GSh-05 зүсэлтийн 15-30 см-т дунд зэрэг, GSh-06 зүсэлтийн бүх үе давхарга, GSh-05 зүсэлтийн 30-50 см гүнд, Зүсэлт-1 22-35 см гүнд маш их карбонатын (CaCO₃) хуримтлалтай байна, Хөрсний бүх зүсэлтүүдэд ялзмагийн агууламжаар бага буюу 0.11-1.67% хооронд хэлбэлзэж байна, цахилгаан дамжуулах чанар (EC) бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор (P₂O₅) болон хөдөлгөөнт кали (K₂O) хангамжаар бага хангагдсан.

Эзэмшлийн талбайд тархсан цайвархүрэн хөрсний бүх үе давхаргуудад 10-30% чулууны агууламжтай, Харин толгодын орой болон дээд хажууд тархсан нимгэн Цайвархүрэн хөрсний доод үе давхаргад чулууны агууламж маш их буюу 70% орчим байна. Хөрсний эзлэхүүн жингээс харахад хөрс нягтавтгар, нягт (1.16-1.32 г/см³) шинж чанартай байна. Хөрсний бүх үе давхарга элсэнцэр, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна (Хүснэгт 28).

Хөрсний бохирдолт: “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн талбай орчмын 2 зүсэлтийн өнгөн үе давхаргын хөрсний дээж сонгож хүнд металл тодорхойлуулсан (Хүснэгт 29). Хөрсний дээжүүдэд 33 химийн элементийг тодорхойлсон боловч тэдгээрийн 12 элемент нь зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь MNS 5850:2019 стандартад нь тусгагдсан байна. Бусад 21 элементүүд нь одоогоор монгол улсад мөрдөгдөх стандарт байхгүй байна. Талбай орчмоос авсан дээжүүд нь “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн стандарт MNS 5850:2019”-тай харьцуулан үзэхэд кобальт (Co), хром (Cr), хар тугалаг (Pb), цайр (Zn), стронци (Sr), ванадий (V), никель (Ni), молибден (Mo), кадми (Cd), цагаан тугалга (Sn), зэс (Cu) зэрэг элементүүд нь хүлцэх агууламжаас даваагүй буюу эдгээр элементүүдын бохирдолгүй байна. Харин GSh-03 Шатахуун түгээгүүрийн орчим хүнцэл (As), GSh-4-р дээжинд хүнцэл (As), молибден (Mo) элементүүд Монгол улсад мөрдөгдөж буй MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байна.

Шатахуун түгээгүүр орчмын цэгийн Хүнцэл (As), хүдэр угаах үйлдвэр орчмын цэгийн Хүнцэл (As), молибден (Mo) зэрэг элементүүд нь Монгол улсад мөрдөгдөж буй (MNS 5850:2019) стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байна. (MNS 5850:2019) стандартын хортой агууламжийн 3.9.2 дах заалт Хортой агууламжийг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах зөвшөөрөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөг болгоно. Хөрсний Молибден (Mo) хортой агууламж 20 мг/кг гэж заасан байна. Тэгэхээр Угаах үйлдвэр орчмын хөрсний дээж уул уурхай, үйлдвэрийн

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу Молибден (Mo) элементийн бохирдолгүй гэж үзэж болно. Харин Шатахуун түгээгүүр болон Хүдэр угаах үйлдвэр орчмын Хүнцэл (As)-ийн бохирдол маш их буюу аюултай агууламжаас их байна. Эрдэс хэлбэрээр байгаа нийт Хүнцэл (As) урвалын идэвх багатай, усанд хялбар уусахгүй, биоидэвхгүй хэлбэрээр ихэвчлэн тархсан байдаг тул ургамал болон хүний биед шууд нөлөө үзүүлэх нь бага байдаг.

Дүгнэлт

“Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн талбай орчим Цайвархүрэн хөрс тархах бөгөөд геоморфологийн хэлбэр, тархалт, онцлог зэргээс шалтгаалан төрлийн хэмжээнд ялгарч байна.

Хөрс нь шүлтлэг урвалын (pH) орчинтой, GSh-07 зүсэлтийн 15-40 см, GSh-05 зүсэлтийн 15-30 см-т дунд зэрэг, GSh-06 зүсэлтийн бүх үе давхарга, GSh-05 зүсэлтийн 30-50 см гүнд, Зүсэлт-1 22-35 см гүнд маш их карбонатын (CaCO₃) хуримтлалтай байна, Хөрсний бүх зүсэлтүүдэд ялзмагийн агууламжаар бага буюу 0.11-1.67% хооронд хэлбэлзэж байна, цахилгаан дамжуулах чанар (EC) бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор (P₂O₅) болон хөдөлгөөнт кали (K₂O) хангамжаар бага хангагдсан, Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага. Цайвархүрэн хөрсний бүх үе давхаргуудад 10-30% чулууны агууламжтай, Харин толгодын орой болон дээд хажууд тархсан нимгэн Цайвархүрэн хөрсний доод үе давхаргад чулууны агууламж маш их буюу 70% орчим байна. Хөрсний эзлэхүүн жингээс харахад хөрс нягтавтарт, нягт (1.16-1.32 г/см³) шинж чанартай байна. Хөрсний бүх үе давхарга элсэнцэр, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна.

2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал

Ургамалжлын бичиглэл: “Говь шоо” ХХК-ийн хайлуур жоншны орд ашиглах төслийн талбайд 4 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь Монгол өвс-харганат, Монгол өвс-боролзойт; Монгол өвс-таана-шавагт, Монгол өвс-шаваг-харганат; Монгол өвс-ерхөг-тэсэгт, Монгол өвс-харганат, Таана-монгол өвст; Таана-монгол өвст төрөл байна. Тус талбай нь цөлөрхөг хээрийн толгод, тэгш хөндийг хамарсан чулуутай ба цэвэр өвслөг ургамалтай байх бөгөөд ургамлан нөмрөгийн 100 м² талбайд 9-18 зүйл, 1м² талбайд 3-6 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын бүрхэц 0-37.2%, га –ийн ургац 1.01-2.532 центнер байна.

1. Монгол өвс-харганат, Монгол өвс-боролзойт (63-60/ У-VI-1-6; У-VI-1-3) цөлөрхөг хээрийн толгодын бүлгэмдэлд (4-р цэг) 100м²-д Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Төлөгчдүү боролз (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Сөөгөн боролз (*Ajania fruticulosa* (Ldb.) Poljak.), буурцагтанаас Алтан харгана (*Caragana leucophloea* Pojark.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.) зонхилж, үетнээс Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), алаг өвснөөс Нарийн навчит янгиц (*Ptilotrichum tenuifolium* (Steph.) C.A.Mey.), Зөөлөвтөр лавай (*Asterothamnus molliusculus* Novopokr.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), бусад овгийн

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

заримдаг сөөг, сөөгөнцөрөөс Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), талхагдлын заагуур ургамлаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Умардын оготнын сүүл (*Enneapogon borealis* (Griseb). Honda.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), сонгинолог ургамлаас Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.) ургасан, нийт 7 овог, 14 төрөл, 17 зүйл ургамал ургасан, 1м²-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 37.2%, түүнээс талхагдлын згаагуур ургамал 7.2%, нийт бүрхцэд хад чулуу 28.6%, хагд 12.0%, халцгай газар 22.2% байна.

2. Монгол өвс-таана-шавагт, Монгол өвс-шаваг-харганат (145a-146б/ЦХ-I-1-4; ЦХ-I-1-5) бүлгэмдэлд (3-р цэг) Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) Алтан харгана (*Caragana leucophloea* Pojark.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), зонхилж, улалжаас Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), алаг өвснөөс Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), Хуурамч дэрвэгэр хавьсгана (*Scorzonera pseudodivaticata* Lipsch.), заримдаг сөөгөнцрөөс Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata* (L.) Schrad.), талхагдлын заагуур ургамлаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Умардын оготнын сүүл (*Enneapogon borealis* (Griseb). Honda.), Сортой лууль (*Chenopodium aristatum* L.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai) Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), зэрэг нийт 100м² талбайд 9 овог, 14 төрөл, 18 зүйл ургамал ургасан, 1м²-д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 7.6%, түүнээс талхагдлын заагуур ургамал 10.0%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 1.8%, хагд 32%, халцгай газар 58.6% байна.

3. Монгол өвс-ерхөг-тэсэгт, Монгол өвс-харганат, Таана-монгол өвст (64-63-148/ У-VI-1-7; У-VI-1-6; ЦХ-I-1-7) бүлгэмдэлд (5 -р цэг) 100м²-д үетнээс Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), сөөгөөс Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей), Сонгинолог ургамлаас Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), буурцагтнаас Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), зонхилж ургасан, алаг өвснөөс Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammannii* Desr.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), заримдаг сөөг, сөөгөнцрөөс Төлөгчдүү боролз (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Зөөлөвтөр лавай (*Asterothamnus molliusculus* Novopokr.), талхагдлын заагуур ургамлаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын оготнын сүүл (*Enneapogon borealis* (Griseb). Honda.), Хянганы хамхуул (*Corispermum chinganicum* Iljin), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), шарилжаас Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), Цагаан навчит шарилж (*Artemisia leucophylla* (Turcz. ex Bess.) Turcz.), нийт 6 овог, 14 төрөл, 15 зүйл ургамал ургасан, 1м²-д 4-6 орчим зүйл тааралдаж байв.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ургамлын тусгаг бүрхэц 5.2%, түүнээс талхагдлын заагуур ургамал 5.6%, нийт бүрхцэд хад чулуу 16%, хагд 45.4%, халцгай газар 33.4% байна.

4. Таана-монгол өвст (158/ ЦХ-I-2-2) бүлгэмдэлд (6 –р цэг) Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), зонхилж, үетнээс Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes songorica* (Roshev.) Ohwi.), улалжаас Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), талхагдлын заагуур ургамлаас Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), заримдаг сөөгөнцөр Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) зэрэг нийт 100м² талбайд 6 овог, 8 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м²–д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 0%, түүнээс талхагдлын заагуур ургамал 8.0%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 3.8%, хагд 34.0%, халцгай газар 62.2% байна.

“Говь шоо” ХХК-ийн хайлуур жоншны орд ашиглах төслийн талбай дахь ургамалжлын өнөөгийн төлөв байдал ба доройтол. Уг талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг гаргахад 147.9 га өвслөг ургамалтай байна. Доройтлын зэргийг тогтоохдоо ургамлан нөмрөгт талхагдлын заагуур ургамал хэдэн зүйл, хэрхэн арвитай ургасан байгаа болон “Бэлчээр газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхагдлыг тодорхойлох” MNS5546:2005 стандартыг харгалзан доройтлын 3 зэрэгт ангилан үзэв. Үүнд:

1. **Хүчтэй доройтсон газар.** Тухайн уурхайн зориулалтаар ашиглаж байгаа талбай дан хог ургамлаар дүүрсэн бөгөөд энд тэнд үүсмэл бүлгэмдэл бий болсон, ургамлан нөмрөг уурхайн үйл ажиллагааны улмаас газрын хөрснөөс арчигдсан 18 га талбай байна.

2. **Дунд доройтсон газар.** Зонхилогч ургамлын арви багасаад нэг настан ба шарилж түрж ургасан, MNS5546:2005 стандартын дагуу мал иддэг ургамлын эзлэх хувь 20-50% болсон, талхагдлын заагуур ургамал 3-4 зүйл бөгөөд тэдгээр нь 31-50% эзэлдэг, ургацын буурал 41-60% болсон байвал дунд доройтсонд хамруулдаг бөгөөд ийм талбай 4.6 га талбай байна.

3. **Сул доройтсон газар.** Үндсэн бүлгэмдлийн зонхилогч дэд зонхилогч нь бүлгэмдэлдээ үүргээ алдаагүй боловч MNS5546:2005 стандартын дагуу мал иддэг ургамлын эзлэх хувь 51% -иас бага болсон, талхагдлын заагуур ургамал 2-4 зүйл бөгөөд тэдгээр нь 10-30% эзэлдэг, ургацын буурал 20-40% болсон байдаг. Ийм доройтсон ургамлан нөмрөг 143.3 га талбай байна.

4. **Доройтоогүй эрүүл хэвийн газар.** Ургамлан бүлгэмдлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүтээмжид өөрчлөлт ороогүй, унаган байдлаараа байгаа ургамлан нөмрөгийг эрүүл хэвийн гэх бөгөөд ийм талбай байхгүй байна.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг

Төслийн уурхайн ба бусад барилга байгууламжууд болон хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Төслийн ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй. Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.

2.8. Нийгэм, эдийн засаг өнөөгийн төлөв байдал:

Баянжаргалан сум нь 1925 онд байгуулагдсан байна. Сум анх байгуулагдахад 200 гаруй өрх, 1000 шахам хүн амтай, 40 орчим мянган толгой малтай, засаг захиргааны нэгж нь 5 багтайгаар зохион байгуулагдан сумын захиргаа үйл ажиллагаагаа эхэлж байжээ.

Баянжаргалан сумын төв нь Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төвөөсөө 150 км-т, Монголын төмөр замаас 80 км зайтай оршдог.

Баянжаргалан сум нь одоо 328.9 мян.км² газар нутагтай, засаг захиргааны хуваариар Аргатай (сумын төв), Шилийн гол, Энгэр-Ус гэсэн 3 багт хуваагдана. Тус сумын нутаг дэвсгэрт жонш, чулуун нүүрс, төмрийн хүдрийн уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг байна.

“Говь шоо” ХХК-ийн “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл (MV-017543)”-ийн талбай нь Энгэр-Ус багийн нутаг дэвсгэрт харьяалагдаж байна. Баянжаргалан сум нь 2019 оны жилийн эцсийн дүнгээр 157.3 мян.толгой малтай байсан байна. Үүнээс 6.69 мянга нь адуу, 3.94 мянга нь үхэр, 0.27 мянга нь тэмээ, 83.68 мянга нь хонь 62.74 мянга нь ямаа байна. Тус сумын 3 багаас Энгэр-Ус баг нь хамгийн олон малтай (82.66 мян.тол), хамгийн олон малчидтай байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

“Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх дараах үндсэн хүчин зүйлс байна. Үүнд:

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарч болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;

- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй.

3.2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Уурхай ба үйлдвэрийн захиргаанаас түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрутыг тогтоон баталж тэмдэгжүүлээгүй, мөн баталсан маршрутаар хийгээгүйн улмаас олон салаа зам үүсэж болзошгүй;
- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай химийн бодисууд ямар нэгэн байдлаар асгарснаар газрын хэвлий болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй;
 - Хүний буруутай үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан ажиллаагүйн улмаас объектуудад осол-аюул гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй;
 - Байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас газрын гадарга, хөрс бохирдож, устаж болзошгүй;
 - Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсэж газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
 - Баяжуулах үйлдвэрийн хатуу хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй;
 - Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Далд уурхайн малталтаас үүдэн тухайн нутгийн газрын доорх ус агуулагч бүрдэл хурдасны зүй тогтол өөрчлөгдөж болзошгүй;

- Баяжуулах үйлдвэрт ашиглаж буй гүний худгийн ашиглалтын нөөц, горимыг буруу тогтоосноос үүдэн худгийн ашиглалтын ундарга буурч болзошгүй;
- Баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүдэн орон нутгийн гадаргын урсцын зүй тогтол алдагдаж, улмаар тухайн нутагт орших байнгын болон түр зуур ус тогтдог нуур, тойрмуудад сөргөөр нөлөөлж болзошгүй;
- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарч Барилгын ажлын үед гарч буй хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар ус бохирдож болзошгүй.
-

3.4. Ургамлан бүрхэвчид, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн уурхайн ба бусад барилга байгууламжууд болон хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Төслийн ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй. Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.

Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлнө. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах;
- **Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;**

Шөнийн цагаар үйлдвэрийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;

- Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам нь үйл ажиллагаанаас амьтдын аймаг, тэдгээрийн амьдралын зүй тогтолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

3.5. Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаа нь 2020 оны 5-р сарын 29-ний өдөр батлагдсан “Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад дүрэм зааврын дагуу явагдах ёстой. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учирч болзошгүй;
- Баяжуулах үйлдвэрийн агааржуулалтын тооцоо алдаатай хийгдэх, агааржуулалтын төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа алдагдах зэргээс үүдэн үйлдвэрийн ажилчдын эрүүл мэнд, амь насанд нь аюул учирч болзошгүй;
- Төслийн дотоод ба гадаад тээвэрлэлтийн буруу зохицуулалт, үйл ажиллагаанаас ослын түвшин нэмэгдэж болзошгүй.

-

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

“Говьшоо” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Говьшоо ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Говьшоо ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож орууллаа.

Говьшоо ХХК-ийн нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав. Мөн уурхайн тухайн жилийн БОМТ төлөвлөгөө тусдаа батлагдаж байгаа тул баяжуулах үйлдвэрт гол анхаарах химийн бодис эрсдэлийн үнэлгээнд зардлыг тусгав.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 750 000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Баяжуулах үйлдвэрт ашиглаж буй уурын зуухнуудаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Агаарын хэмжилт хийх	Баяжуулах үйлдвэрт	Ш	2		200 000		--MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982
5.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
2	Химийн бодис асгарах	Асгаралтын бүрдэлийг иж бэлэн байлгах	Баяжуулах үйлдвэр дотор	Иж бүрдэл	250 000	1	250 000		Химийн бодисын тухай хууль
3	Орчны тоосжилт нэмэгдэх	Баяжуулах үйлдвэрийн тойруулан хайлаас мод тарих	Баяжуулах үйлдвэр орчим	Ш	2000	600	1200 000		
5.3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж									
4	Хаягдлын санд химийн бодисын агууламж ихээр агуулагдах	Хаягдлын сангаас дээж хэмжилтийг тогтмол хийх	Хаягдлын сан	Ш			ОХШ зардалд орсон		
5	Хаягдлын сангийн доторлогоог цоорох	Хаягдлын сангийн шалгалтыг дотоод журам боловсруулж байнга хийх	Хаягдлын сан				300 000		
	Нийт						1950 000		

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн тухайн жилийн БОМТ-д дэлгэрэнгүйн тусгагдсан болно.

**БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, ТЭРБУМ
МОД ХӨТӨЛБӨРИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уурхайн тухайн жилийн БОМТ-д дэлгэрэнгүйн тусгагдсан болно.

**БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тусгай зөвшөөрлийн талбайд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй тул үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс баяжуулах үйлдвэрийн 2024 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1000 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 18. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2024 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	Аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө 2023 батлуулах	Уурхайн бүх объектод хамаарна.	1	500.000 төг		7 сард	ОБЕГ-ын даргын 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид			Үйл ажиллагааны зардалд орно.		
3	Гал түймэр гарах	Төслийн талбайд галын хор байршуулах	Кемп, үйлдвэр, засварын цэгт	2 ш	250000	500 000	Улиралдаа 1 удаа цэнэглэх	
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	ХААБ мэргэжилтэн			
	Нийт					1000 000		

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төсөл нь тогтвортой хэрэгжих төсөл учраас хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн аймгийн БОГазраас хог хаягдлыг ангилан ялгах, ангилан ялгасан энгийн болон аюултай хог хаягдлыг дахивар авах цэгт хүргүүлэх ажлыг хийхийг зөвлөсөн. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг яагаад ялгах тухай сургалтыг хийх, мөн уурхайн кемпэд 2 ширхэг ангилан ялгах зориулалттай хогийн савыг суурьлуулах, аюултай хог хаягдлыг ахуйн хаягдлаас тусад нь хадгалах зориулалттай контейнерт хадгалах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Зураг
1.	Аюултай	Аюултай хог хаягдлыг хадгалах	Хадгалагдсан баттерей, аккумулятор, тосны шүүр, тосны хаягдал сав	Ш	200 л пошк 1	200 000	200 000	6-р сард	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга	
	Нийт					200 000	200 000			

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 12. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Жонш баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн технологийн үйл ажиллагаанд нийт 4 төрлийн химийн бодис, лабораторид 7 төрлийн бодис ашиглагдана.

Хүснэгт 20. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Химийн бодисын хадгалалт, ашиглалтын стандарт, дүрэм журам мөрдөөгүй улмаас эрсдэл үүсэх	Химийн бодис бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих	Сургалт зохион байгуулах ба бүртгэлжүүлэх	Удаа	600.0	Жилд 1 удаа	600.0	Жил бүр	Химийн хот болон аюултай бодисын тухай хууль
Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлаас бохирдол үүсэх агсарч гоожих	Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдсэн химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагад	Химийн бодисын сав баглаа боодол	Удаа	1200	Жилд 1 удаа	1200.0	Жил бүр	Химийн хот болон аюултай бодисын тухай хууль

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	шилжүүлж устгуулах							
Баяжуулах үйлдвэрт ажиллаж байгаа ажиллагсад хордох эрсдэлд өртөж болзошгүй	Баяжуулах үйлдвэрийн химийн бодистой харьцан ажиллаж байгаа ажиллагсдыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах	Баяжуулах үйлдвэр ба лаборатори	ш	170.0	4	680		
	Нийт зардал					2480.0		

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Говь-шоо ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. "Говь шоо" ХХК хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, нормоос хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Агаарын чанарт 2 цэгт, хөрсөн бүрхэвч 2, хаягдлын сангийн 1 цэгт тус бүр хэмжилт дээжлэлтийг хийхээр төлөвлөсөн. Нийт зардалд 282 000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 21. 2024 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Бүрэлдэ хүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Температур, нийт тоосжилт, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Азотын давхар исэл,	107° 52' 7.309" 45° 34' 53.824" 107° 52' 2.561" 45° 34' 51.697"	Жилд 1 удаа, 2 цэгээс. Шаардлагат ай тохиолдолд тухай бүрт нь.	20 минутын хэмжилт хийж (SO ₂ , NO ₂ , тоос)- ийг хамт тооцоход 47.0 мян.төг	94.0	– MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал- Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал- Агаарын дээжилт шинжилгээ – MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга – MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий- CO ₂ тодорхойлох эзэлхүүний арга – MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга
Хөрсөн бүрхэвч	Хөрсний хүнд металлын шинжилгээ	Баяжуулах үйлдвэр орчимд 107° 52' 2.154" 45° 34' 55.223" 107° 52' 0.322" 45° 34' 52.336"	Жилд 1 удаа, 2 цэгээс	Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 60 мян.төг <i>*Эс жи Эс лаб ХХК үнэ авав.</i>	120.0	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бүрэлдэ хүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин	Усны хүнд металын шинжилгээ	Хаягдлын сангаас 107° 52' 2.364" 45° 34' 52.148"	1 удаа .	58.0	58.0	<ul style="list-style-type: none"> - MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ - MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага - MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх - MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох - MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах - MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга - MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Нийт				272.0	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 4. Орчны хяналт шинжилгээ авах цэгийн байршил



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний дээж авах цэгийн координат

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
Усны дээж авах цэг		
1	107 ⁰ 52' 2.364"	45 ⁰ 34' 52.148"
Хөрсний дээж авах цэг		
1	107 ⁰ 52' 2.154"	45 ⁰ 34' 55.223"
2	107 ⁰ 52' 0.322"	45 ⁰ 34' 52.336"
Агаарын мониторингийн цэг		
1	107 ⁰ 52' 7.309"	45 ⁰ 34' 53.824"
2	107 ⁰ 52' 2.561"	45 ⁰ 34' 51.697"

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уурхайн тухайн жилийн БОМТ-д дэлгэрэнгүйн тусгагдсан болно. Баяжуулах үйлдвэрийн байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн энэхүү ажлын зардалд 3000 000 төгрөг зарцуулна.

**БҮЛЭГ 15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Уурхайн тухайн жилийн БОМТ-д дэлгэрэнгүйн тусгагдсан болно.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН
ТӨСӨВ, ДҮГНЭЛТ**

“Говь шоо” ХХК-ийн Логийн хайлуур жоншны орд нь засаг захиргааны харьяаллын хувьд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км-т, Дундговь аймгийн Баянжаргалан сумаас өмнө зүгт 28 км-т, Чойрын төмөр замын өртөөнөөс баруун урагш 110 км-т, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн зүгт 150 км-т тус тус байрлана.

“Говь шоо” ХХК нь “Логийн хайлуур жоншны ордын I хүдрийн биетийн өмнөд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах төсөл (MV-017543)”-ийн талбайд 2015-2018 онд хайгуулын ажил гүйцэтгэн, ордын хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой зэргээр $V+C=224.68$ мян.тн-оор Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Логийн хайлуур жоншны ордыг анх 1955 онд нээсэн байна. Д.Цогтбаяр, С.Мягмар нар 1988-1990 онуудад Хөх дэлийн хүдрийн талбайд эрэл-үнэлгээний ажил явуулсан бөгөөд уг талбайн нь Сүүл-Өндрийн хүдрийн зангилааны өмнөд жигүүрт багтжээ. Ус эрлийн ажлын явцад Сүүл-Өндрийн зангилааны хэмжээнд хайлуур жоншны 30 орчим хүдрийн биет ялган 7 бүс тогтоож, эдгээрийн жоншны нийт нөөцийг 2313 мян.тн-оор тогтоосон байдаг.

“Жонш баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн үйл ажиллагаанаас газрын хэвлийд дам байдлаар сөргөөр нөлөөлөх бөгөөд газрын гадаргын 2000-3000 м² талбайд хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн барилгын ажлын үед 3000 м² газрын гадаргад хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх боловч үйлдвэр баригдаж дууссанаар 2114 м² хэмжээтэй газрын гадарга үйлдвэрийн барилгад дарагдахаар байна

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ордыг ашиглах хугацаанд 56.9 %-ийн хайлуур жоншны агуулгатай нийт 162.3 мян.тн хүдэр олборлон 1-р шатны бутлуураар бутлан ангилж ФК-75 маркийн 87.5 мян.тн металлургийн баяжмалыг гар аргаар ялган хэрэглэгчдэд нийлүүлнэ.

2. Үлдэх 35 %-ийн дундаж агуулгатай 74.8 мян.тн хүдрийг 2-р шатны бутлуурт бутлан 0-5 мм, 5-15 мм, 15-30 мм-ээр ангилан ялгаж үлдэх 5-15 мм болон 15-30 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг хүндийн хүчний аргаар баяжуулах төхөөрөмжид баяжуулан ФГ-85 маркийн баяжмал үйлдвэрлэнэ.

3. Нийт жоншны хүдрийн 54.04 хувийг эзэлж буй 0-5 мм-ийн ширхэглэлтэй болон тунаан баяжуулалтын хаягдал нь флотацийн үйлдвэрийн тэжээл болох юм. Энэ дунджаар 37.62 хувийн агуулгатай байна.

Хайлуур жоншны хүдрийг гравитаци, флотацийн аргаар баяжуулах технологийг сонгохдоо захиалагч талаас ирүүлсэн төслийн техникийн даалгавар болон Логийн хайлуур жоншны хүдрийг “Минлаб” ХХК-д боловсруулсан технологийн туршилтын тайлангийн үр дүн, санал зөвлөмжид тулгуурлан баяжуулах технологийг сонгон доор дурдсан технологийн ерөнхий шийдлүүдийг гаргасан байна.

Уурхайгаас олборлосон хүдрээс эхлээд гар аргаар ялгалт явуулан ФК-75 маркийн бүхэллэг баяжмалыг ялган авч үлдэгдэл хүдрийг гравитаци болон флотацийн аргаар баяжуулан ФГ-85, ФФ-95 маркийн баяжмал гарган авна. 2023 онд ФФ-95 маркийн 4.59 мян.тн, ФГ-85 маркийн 5.60 мян.тн, ФК-75 маркийн 8.26 мян.тн баяжмал гарган авна.

Эдийн засаг: 2023 онд уурхайд 70-н ажилтан ажиллана. ФФ-95, ФГ-85 ба ФК-75 маркийн баяжмалыг БНХАУ-д борлуулна. 2024 онд нийт 9352.355 сая.төг-ийн борлуулалт хийж 6751.79 сая.төг-ийн зардал гарган ажиллана.

“Говьшоо” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Говьшоо ХХК-ийн нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 23. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1 950 000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	Уурхайн БОМТ-д тусгасан
3	Дүйцүүлэн хамгаалах тэрбум мод арга хэмжээний төлөвлөгөө	
4	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 000 000
7	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	200 000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	272 000
9	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2 480 000
10	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал	3000 000
	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	8 902 000

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **8 902 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 4 451 000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ХАВСРАЛТ

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр: "Говьшоо" ХХК
2. Төслийн байршил: Дундговь аймаг, Баянжаргалан сум, Лог
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: Баяжуулах үйлдвэр
4. Огноо: 2024.03.28

5. Ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээний дундаж онооны үзүүлэлт

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд 1	Авсан байвал зохих оноо 2	Ажлын хэсгийн гишүүдийн дундаж оноо 3	Үндэслэл, тайлбар 4
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	15.8	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл сайн хэрэгжсэн.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	27.4	Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	Дүйцүүлэн хамгааллыг сайн хувьтай хэрэгжүүлсэн.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	5	Маргаан үүсээгүй.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	Түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон зөрчил илрээгүй.
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	Осол эрсдэлийн менежмент сайн хэрэгжсэн.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	3.7	Хог хаягдлын менежмент сайн хэрэгжсэн.
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	Төлөвлөлтийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.
9	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4.2	Орон нутгийн уялдаа холбоог сайжруулах, удирдлагын хяналт сайн.
10	Аймаг, сум орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон	5	4	Нөлөөллийн бүсэд оршин суух иргэдэд тайлагнаж, санал хүсэлтийг авч

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт			ажилласан.
Нийт оноо	100	90.1	90.1%

6. Нэгдсэн дүгнэлт

Тус аймгийн Баянжаргалан сумын жонш баяжуулах үйлдвэрийн тус аж ахуйн нэгжийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/420 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж 90.1 оноо буюу 90.1 хувьтай дүгнэсэн.

7. Санал, зөвлөмж

7.1 2024 оны БОМТөлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу боловсруулж, батлуулахад анхаарах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу хийгдэх ажлыг сайтар төлөвлөж, хэрэгжүүлэх.

7.2 Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах.

7.3 Олборлолт, тээвэрлэлтийн үед зам арчилгааг сайжруулах, тоосжилтыг бууруулахад онцгойлон анхаарах.

7.4 Компанийн санхүүгийн нэгж төслийн БОМТөлөвлөгөөний зардлыг бүрэн гаргаж үр дүнг дээшлүүлэхэд анхаарах.

7.5 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд заагдсан тусгай хамгаалалттай газарт дүйцүүлэн хамгааллын аргачлалын дагуу төлөвлөн хийж хэрэгжүүлэх, тайлагнах.

7.6 2024 оны тайланг заасан хугацаанд буюу 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

7.7 Ус ашиглахтай холбоотой асуудал үүссэн тохиолдолд холбогдох төрийн байгууллагад мэдэгдэж ажиллах

7.8 Үйлдвэрийн бүтээгдэхүүн боловсруулахад ашиглаж байгаа уснаас хаягдал усны сорьцын шинжилгээг улирал тутам өгөх

7.9 Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах. (Гурвалсан гэрээ)

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7.10 2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайлангийн чанар, эмх цэгцэд анхаарч, баримт бичгийн стандартад нийцүүлж, тайлангийн хавсралтыг журмын дагуу бүрэн бүрдүүлсэн үед ажлын хэсэг хүлээн авахыг тус тус зөвлөж байна.

8. 2024 оны төлөвлөгөөнд тусгах зайлшгүй арга хэмжээ

8.1 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан бохирдлын үзүүлэлтүүдийг сүүлийн 2-3 жилээр харьцуулан гарсан бохирдлыг бууруулах арга хэмжээг сайтар төлөвлөх.

8.2 Хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгаж дахивар авах цэгт тушааж хэвших.

8.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговьго ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ төлөвлөж, үр дүн гарган ажиллах.

8.4 Хаягдлын далангаас тогтмол сорьцын шинжилгээ авч ажиллах

8.5 “Аргын хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт биотехникийн арга хэмжээ авах

8.6 Байгаль орчны аудит хийлгэх

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

ХЯНАСАН:

Н.ГАНТУЛГА (БОАЖГ-ын дарга)

НЭГТГЭН ДҮГНЭСЭН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.НЯМТУЯА
(БОАЖГ-ын мэргэжилтэн)

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

Н.СОЛОНГО

(УГХДТСГЗ-ны мэргэжилтэн)

Х.САРАНГЭРЭЛ

(Баянжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэн)

П.Очирбал

(Баянжаргалан сумын иргэний төлөөлөл)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

С.ГАНБААТАР

(“Говьшоо” ХХК-ийн гүйцэтгэх захирал)

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Говьшоо ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэр ашиглах төсөл

UFC

ГОЛОМТ БАНК
Саян тайвны санхүүжилэл

ТӨЛБӨРИЙН БАРИМТ / APPLICATION FOR REMITTANCE

Он сар өдөр 2024 10 1	Дүн / Amount =4,451,000.00=	Үсгээр / In words (ДЕРВЕН САЯ ДЕРВЕН ЗУУН ТАВИН НЭГ МЯНГАН ТӨГРӨГ)	
Мөнгөний нэгж / Currency <input checked="" type="checkbox"/> MNT <input type="checkbox"/> USD <input type="checkbox"/> Бусад		Төлбөрийн зориулалт / Details of payment ГОВЬШОО ХХК БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ	
ХЭНЭЭС / FROM IBAN: MN94001500	Дансны нэр / Account name БОЛОРЧИМЭГ АРААНЗ	Төлбөрийн зориулалт / Details of payment ГОВЬШОО ХХК БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ	
	Дансны дугаар / Account No 1 1 0 9 2 4 0 8 2 9		
ХЭНД / TO IBAN:	Банкны нэвтрэн / Bank name ТӨВИЙН БАНК	Гарын үсэг / Signature 1st <i>Н.Самуу</i>	Тамга / Stamp
	Дансны нэр / Account name БОНХОМ САРГАА БАТАЛГАА	2nd	
	Дансны дугаар / Account No 1 0 0 9 0 0 0 1 3 4	3rd	
ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГ / FOR BANK USE ONLY		ТЭМДЭГЛЭЛ / NOTE:	
ХҮА / TELLER	ГОЛОМТ БАНК 92	Шилжүүлэх данс	1109240829
Хянасан / Verified by	<i>10/24/10/01</i>	Хүлээн авах данс	1009000131106
ӨН / DATE	<i>10/24/10/01</i>	Хүлээн авах дансны нэр	БОНХОМ
	<i>10/24/10/01</i>	Хүлээн авагчийн банк	МОНГОЛЫН САХ
		Мөнгөн дүн	4451000